

## ГАРЧИГ

- 2–4 Бодлогын нийтлэл
- 5–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Ярилцлага
- 10–11 Тогтвортой санхүүжилт
- 12 Компанийн засаглал, комплайнс
- 13–15 Финтек ба регтек
- 16–23 Судлаачийн индэр
- 24–25 Санхүүгийн салбар дах хиймэл оюун ухааны хэрэглээ
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## ISO 37301 НИЙЦЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

**Нийцэл** гэж юу вэ? Оксфордын толь бичигт “compliance” буюу нийцэл гэх үгийг эрх мэдэл бүхий хүмүүсийн гаргасан дүрэм буюу хүсэлтийг даган биелүүлэх үйл ажиллагаа гэж тайлбарлажээ. “Нийцлийн менежмент”, “нийцлийн менежментийн тогтолцоо” гэх үгс хариуцлагаа ухамсарласан бизнес эрхлэгч, эрдэмтэн судлаачдын дунд яригдаад нэлээдгүй хугацааг өнгөрөөв.

Аливаа компани үйл ажиллагаа явуулж буй салбар, чиглэлээсээ хамааран олон төрлийн хууль тогтоомж, дүрэм журам болон бусад шаардлагыг мөрдөн ажиллах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах, хяналт, шалгалтад хамрагдах зэрэг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй тулгардаг. Төрийн эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлэн ажиллах нь нэг удаагийн шинжтэй биш бөгөөд компанийн бүхий л үйл ажиллагааг хамардаг.

Бизнесийн байгууллага хууль тогтоомж, дүрэм журмыг байнгын шинжтэйгээр, бүх үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай болдог нь “нийцлийг хангах” хэрэгцээ шаардлага чухал болохыг харуулж байгаа бөгөөд нэг удаагийн бус өргөн цар хүрээг хамарсан “нийцүүлэх” үйл ажиллагааг компани нь дотооддоо эмх цэгцтэй, тодорхой хяналттай зохион байгуулах шаардлагатай тулгарч эхэлдэг. Үүнээс үүдэн, “нийцлийн менежмент”, “нийцлийн менежментийн тогтолцоо” гэх ойлголт бий болжээ.

“Нийцлийн менежмент” гэдэг нь тухайн байгууллага төрөөс баталсан хууль тогтоомж, дүрэм журам болон үйл ажиллагааны салбарт мөрдөгддөг бусад стандарт шаардлагууд болон компанийн дотооддоо баталсан бодлого, журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн стратегийн үйл явц буюу бизнесийн дотоод чиг үүрэг юм. Энэ нь төрийн байгууллагаас ногдуулж болох торгууль шийтгэлээс урьдчилан сэргийлж, компанийн нэр хүндийг хамгаалж, хөрөнгө оруулагч, түншүүдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хүрээнд тавигдсан шаардлагуудыг нэгтгэн тогтоож, хяналтыг хэрэгжүүлж, тогтмол аудит явуулж, засан сайжруулах арга хэмжээ авахыг хэлнэ.

Мөн “Нийцлийн менежментийн тогтолцоо” гэдэг нь хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бүх хууль тогтоомж, дүрэм журам, стандарт шаардлагуудыг нэгтгэн тогтоож, түүнд үйл ажиллагаагаа нийцүүлэх арга хэмжээг удирдаж, сайжруулахад нь компанид дөхөм болох дотоод бодлого, журам, хяналт, технологи зэргийн иж бүрдлийг хэлдэг аж. Энэхүү тогтолцоо нь хуулиар тогтоосон үүрэг шаардлагуудыг нэг мөр ойлгож, түүний талаарх ажилтнуудын мэдлэгийг нэмэгдүүлж, бизнесийн үйл ажиллагаанд нийцлийн үйл ажиллагааг нэвтрүүлж, хэрэгжилтийг хянан шалгаж, аудит явуулж, засан сайжруулах үйл явцыг хамардаг.

Нийцлийн менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлснээр тухайн компани, байгууллагад төрөл бүрийн ашиг тусыг авчирдаг. Тухайлбал, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт сайжирч, үйл ажиллагаанд учирч болох эрсдэл буурч, компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний гологдол, үрэгдэл багасаж, чанар дээшилдэг. Мөн хэрэглэгч, хөрөнгө оруулагч, түнш болон бусад бизнесийн холбогдолтой оролцогч талуудын итгэлийг олж авах, нэмэгдүүлэх сайн талтай. Энэ нь компанийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, компанийн дотоод нэгж, салбаруудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангадаг.



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### Хянан шалгагчийн хяналт, үнэлгээний үйл явц

Supervisory Review and Evaluation Process (SREP)

Банк, санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалтыг удирдан чиглүүлж, өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар зэрэгт хамгийн бага шаардлагуудаас гадна боломжит нэмэлт шаардлагуудыг хэрэгжүүлэх, эсхүл бусад хяналт шалгалтын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлох үйл явц.



### Хувьцаат компани

Public company

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь эрх бүхий байгууллагад бүртгэгдэж, тодорхой хүрээнд арилжаалагддаг компани. Хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай гэсэн төрөлтэй байна. Нээлттэй хувьцаат компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ. Хаалттай хувьцаат компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.

*Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь 2024 он*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ОРНУУД ДАХЬ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ДАРААГИЙН ҮЕ

Ази, Номхон далайн бүс нутаг нь Сингапур, Австрали, Япон зэрэг өндөр хөгжилтэй санхүүгийн системээс эхлээд хурдацтай хөгжиж буй орнуудыг хамарсан олон талт санхүүгийн экосистемтэй. Зохицуулалтын орчин, технологийн хөгжил, институцийн бүтцийн онцлогоос шалтгаалан улс орон бүрийн санхүүгийн зах зээлийн хөгжил өөр, өөр түвшинд явж байгаа хэдий ч энэ бүс нутаг нь дэлхийн хамгийн эрчимтэй өсөлттэй, технологийн дэвшлээр тэргүүлж буй санхүүгийн системтэй юм.

Сүүлийн жилүүдэд зөвхөн санхүүгийн байгууллагууд төдийгүй зохицуулагч байгууллагууд ч мөн адил хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, хурдан хувьсан өөрчлөгдөж буй санхүүгийн орчинд дасан зохицохын тулд хяналт, шалгалтын технологийн шийдлүүдийг идэвхтэй нэвтрүүлж байна. Кембрижийн Их Сургуулийн харьяа Суптек Лаб-ын жил бүр гаргадаг “Суптек зах зээлийн өнөөгийн байдал” тайланд дурдсанаар, 2024 онд Ази, Номхон далайн бүс нутгийн санхүүгийн зохицуулагчдын 67 хувь нь аль хэдийн суптек хэрэглээг нэвтрүүлсэн бөгөөд 50 хувь нь хоёр ба түүнээс дээш төрлийн шийдэл ашиглан хяналт шалгалтын үйл ажиллагаагаа гүйцэтгэж байна. Гэвч байгууллагын түвшинд шат дараалсан шилжилт хийх цогц стратеги боловсруулах ажил дөнгөж эхэлж байгаа бөгөөд бүс нутгийн байгууллагуудын 16 хувь нь л бүрэн стратеги боловсруулсан, харин 67 хувь нь боловсруулалтын шатандаа байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, кибер аюулгүй байдал, уур амьсгалын эрсдэлийн хяналт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд суптек хэрэглээ хамгийн өргөн байна (SupTech Lab, 2024).

Энэхүү нийтлэлээр Ази, Номхон далайн бүсийн орнуудад суптекийн хөгжил хэрхэн өрнөж, энэ бүс нутгийн зохицуулагч байгууллагууд технологийн тусламжтайгаар хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа хэрхэн дараагийн түвшинд хүргэж буй туршлагаас хуваалцахыг зорилгоо.

**Хиймэл оюун ухаанд суурилсан бодлого, шинжилгээний хэрэгслүүд:** Хиймэл оюун ухаан (AI) болон үүсгэгч хиймэл оюун ухаан (Generative AI) нь санхүүгийн салбар дахь эрсдэлийн үнэлгээ, бодлого шинжилгээг шинэ түвшинд гаргаж байна. Энэтхэгийн Төв банк арилжааны банкуудын хөрөнгө оруулалтын багц болон хүүгийн свопын зах зээлийн эрсдэлийг хянах дотоод системийг хөгжүүлжээ. Уг шийдэл нь олон төрлийн эх сурвалжаас өгөгдөл цуглуулж, баталгаажуулсны дараа үүсгэгч хиймэл оюун ухааны тусламжтайгаар хөвөгч хүүг урьдчилан таамаглаж, хөрөнгө оруулалтын багцын мэдрэг байдлыг үнэлдэг.

Мөн эх хэлний боловсруулалтыг ашиглан банкуудын удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн төрөл болон хэлэлцүүлгийн өнгө аясыг ангилан үнэлэх замаар засаглалын болон үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж байна. Энэтхэгийн Төв банкны эдгээр шийдэл нь машин сургалт болон статистикийн аргуудыг хослуулан санхүүгийн систем дэх эмзэг байдлыг илрүүлэх,

эрсдэлийн суурьтай хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Тайландын Төв банк ч мөн адил хиймэл оюун ухааныг ашиглан удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, хэлэлцэх асуудлын бүтэц дээр дүн шинжилгээ хийж, засаглалын үнэлгээг уламжлалт аргаар бус, автомат аргаар гүйцэтгэж байна. Түүнчлэн, бодлогын төвөгтэй асуудлыг энгийн иргэдэд ойлгомжтой тайлбарладаг олон агент чатбот болон технологийн ахисан түвшний мэдлэггүй хянан шалгагчдад зориулсан их өгөгдлийн менежментийн SQL туслах хэрэгслийг нэвтрүүлсэн.

Индонезийн Санхүүгийн Үйлчилгээний Зохицуулах Газар (OJK) нь хэрэглэгчийн зан төлөв болон зах зээлийн чиг хандлагыг илрүүлэх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан сэтгэл хөдлөлийн шинжилгээний хэрэгсэл ашиглаж байна.

**Мөнгө угаах эрсдэлийг илрүүлэх системүүд:** Технологийн дэвшлийг өргөн хүрээнд ашиглаж буй хяналт, шалгалтын нэг чиглэл нь мөнгө угаахтай тэмцэх хяналт юм. Малайзын Төв банк бүтэцлэгдсэн болон бүтэцлэгдээгүй машин сургалтын загваруудыг ашиглан сэжигтэй гүйлгээ, сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх систем хөгжүүлсэн бөгөөд энэхүү систем нь санхүүгийн байгууллагуудаас ирүүлдэг тайлан мэдээ, аудитын тайлан болон комплайнсын үнэлгээ зэрэг өгөгдлийг давхар ашигладаг.

Австралийн санхүүгийн гүйлгээний төв нь Финтрак нээлттэй эхийн системийг боловсруулсан бөгөөд тус систем нь гүйлгээний түүх болон криптографийн аргыг ашиглан сэжигтэй гүйлгээг илрүүлэх, өгөгдлийн нууцлалыг алдалгүйгээр хил дамнасан хяналт, шинжилгээ хийх боломжийг олгож байна.

**Уур амьсгалын өөрчлөлт ба ногоон технологи:** Уур амьсгалын эрсдэл дэлхий нийтийн анхаарал хандуулах эрсдэл болоод буй өнөө үед санхүүгийн зохицуулагч байгууллагууд ч мөн адил хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулж эхэлж байна. Индонез, Вьетнам, Филиппин улсуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд суптек шийдлийг ашиглан хөдөө аж ахуй болон ойн салбар дахь уур амьсгалын эрсдэлийг хянах, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Сингапурын Төв банк нь уур амьсгалын эрсдэл, байгаль орчны эрсдэлийн үнэлгээг стресс тест, эдийн засгийн загваруудад оруулж, банк болон даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлж байгаа бол Австралийн Санхүүгийн зохицуулалтын газар нь уур амьсгалын эрсдэлийн сценар шинжилгээг 2050 оныг хүртэлх хугацааг хамруулан үнэлж, газар зүйн байршлын онцлог шинжид тулгуурлан нэг гудамж, нэг барилга байгууламжийн

хүрээнд нарийвчилсан эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж байна. Мөн Австралийн санхүүгийн зохицуулагч байгууллага нь уур амьсгалын эрсдэлтэй холбоотой даатгалын зардлын өсөлт, тэдгээрийн санхүүгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж буйг судлан хяналт тавьдаг.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах технологи:** Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудын тэргүүлэх чиг үүрэг юм. Филиппиний Төв банк нь Төв банкны цахим туслах хэмээх хиймэл оюунд суурилсан чатботыг нэвтрүүлж, өргөдөл гомдол шийдвэрлэлтийг автоматжуулах, санхүүгийн залилан, луйврын шинжтэй үйлдлийг илрүүлэх, зах зээлийн хяналтад зориулсан мэдээлэл цуглуулах боломжийг бүрдүүлсэн байна. Мөн Филиппиний Төв банк нь “дигитал хяналтын платформ”-ыг хөгжүүлж буй бөгөөд энэ нь санхүүгийн зохицуулагч байгууллагууд, хяналтын нэгжүүдийн мэдээллийг нэгтгэж, нэгдсэн хяналт, шалгалтын аргачлалыг бүрдүүлэх, шинээр үүсэж буй хэрэглэгчийн эрсдэлийг бодит цагийн горимоор хянах боломжийг олгох юм.

**Суптек нэвтрүүлэхэд тулгарч буй сорилт болон шийдэл:** Зах зээлийн хурдтай өөрчлөлт, шинэ технологийн хөгжил, санхүүгийн байгууллагуудын чадавх зэргээс шалтгаалан хяналт, шалгалтын үйл ажиллагаанд технологи нэвтрүүлэхэд олон төрлийн сорилт тулгарч байна.

Филиппиний Төв банк нь API-д суурилсан тайлагналын платформыг нэвтрүүлэхдээ 400 гаруй арилжааны банкуудын технологийн ялгаанаас шалтгаалсан бэрхшээлтэй тулгарсан. Бага хэмжээтэй, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын хувьд технологийн боломж муу, дэд бүтэц сул, санхүү, хүний нөөцийн хязгаарлалтаас болж тус системийг нэвтрүүлэхэд хүндрэл үүсэж байсан. Тус асуудлыг байгууллагын үйл ажиллагааны цар хүрээнээс хамааруулан ялгаатай систем хөгжүүлэх, тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэх замаар шийдвэрлэж байна.

Мөн хяналт, шалгалтын технологийг нэвтрүүлэхэд туршилтын шатнаас шилжин үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх процесс нь хамгийн хүнд сорилт гэж зохицуулагч байгууллагууд онцолж байна. Суптек шийдлүүд нь туршилтын орчинд сайн ажилладаг хэдий ч бодит хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх үед техникийн доголдол болон бусад төрлийн хязгаарлалт үүсэх тохиолдол их байдаг. Иймд хянан шалгагчид хамгийн төгс хувилбарыг нэвтрүүлэх биш зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа, функцуудыг эхэлж нэвтрүүлэн, тасралтгүй сайжруулалт хийж явах нь илүү үр дүнтэй юм.

Дан ганц технологийн хөгжлөөс гадна суптекийг амжилттай нэвтрүүлэхэд засаглал, уян хатан зохицуулалт, хүний нөөцийн чадавх зэрэг чухал нөлөөтэй. Иймд санхүүгийн зохицуулагч

байгууллагууд нь өөрчлөлтийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэн, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, технологийн чиглэлд мэргэшээгүй хянан шалгагчдад зориулсан системийг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын шаардлагуудыг хангах зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.

Санхүүгийн зохицуулагч байгууллагууд хяналт, шалгалтын үйл ажиллагаандаа хиймэл оюун ухаан болон бусад төрлийн технологийг эрчимтэй нэгтгэж буй энэ үед шударга, ил тод байдал, хариуцлагыг хангуулах шаардлагатай юм. Сингапурын Төв банк нь “Тэгш, ёс зүй, хариуцлага, ил тод байдал”-ын зарчмыг нэвтрүүлсэн нь бүс нутгийн хэмжээнд жишиг болох зохицуулалт болсон бөгөөд хиймэл оюун ухаан болон үүсгэгч хиймэл оюун ухааны загварыг ашиглахдаа аливаа төрлийн тэгш бус байдлыг бууруулах, шийдвэр гаргалтад хариуцлага хүлээх засаглалын шаардлагуудыг тус зарчмаар тогтоодог.

Улс орнуудын зохицуулагч байгууллагууд хяналт, шалгалтын үйл ажиллагаандаа технологийг амжилттай нэвтрүүлж буй хэдий ч санхүүгийн үйл ажиллагаа газар зүйн байршлаар үл хязгаарлагдан хил дамнан хөгжиж буй энэ цаг үед зохицуулагч байгууллагуудын нийцэл, хамтын ажиллагаа санхүүгийн зах зээлийн хөгжилд чухал үүрэгтэй болж байна. Ази, Номхон далайн бүс нутагт хамтын ажиллагааны олон нэгдэл үүсэж байгаа бөгөөд үүний нэг жишээ нь 2024 оны 7 дугаар сард эхэлсэн Нексус төсөл юм. Тус төсөл нь Малайз, Филиппин, Сингапур, Тайланд, Энэтхэгийн Төв банкууд төлбөр тооцооны системээ уялдуулан, хил дамнасан төлбөр тооцоог, түргэн шуурхай, найдвартай болгон хөгжүүлэх зорилготой юм. Мөн эдгээр улс орнуудын хяналт, шалгалтын технологид зориулсан зохицуулалтын сэндроксыг эхлүүлж буй бөгөөд энэ нь шинэ хяналтын технологийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэхээс өмнө туршиж, сайжруулах зорилготой хяналттай орчин юм.

**Ирээдүйн чиглэл:** Цаашид Ази, Номхон далайн бүс нутгийн зохицуулагч байгууллагууд хяналт, шалгалтын дараах чиглэлүүдэд төвлөрөн технологийн дэвшлийг нэвтрүүлэх төлөвтэй байна.

- ◆ **Бодит цагийн эрсдэлийн хяналт:** Төлбөр тооцооны үйл ажиллагаанд гардаг залилан, мөнгө угаах эрсдэлтэй гүйлгээ, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор илүү нарийн, хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын хэрэгслүүдийг хөгжүүлэх.
- ◆ **Өгөгдөл ба шинжилгээний шинэ эх үүсвэрүүд:** Хиймэл оюун ухаанд суурилсан өгөгдлийн шинжилгээг өргөжүүлснээр шинээр үүсэж буй эрсдэлийг илүү

нарийвчлан илрүүлэх боломжийг бий болгох.

- ◆ **Салбар хоорондын уялдаа:** Суптек шийдлийг банк, даатгал, үнэт цаас, финтек зэрэг санхүүгийн бүх салбаруудын хяналттай уялдуулан нэвтрүүлснээр хяналт, шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй, нэгдсэн болгож, салбар хоорондын зөрүүг бууруулах.
- ◆ **Хэрэглэгчийн хамгаалалт:** Дижитал санхүүгийн орчинд хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн технологийн шийдэл, тэдгээрийн хэрэглээг өргөжүүлэх.

Ази, Номхон далайн бүс нутаг дахь санхүүгийн салбарууд хөгжлийн түвшин, зохицуулалтын орчин, институцийн чадавхаараа ялгаатай хэдий ч сүүлийн жилүүдэд технологийн хурдтай өсөлт болон түүнд нийцсэн зохицуулалтын шинэчлэлээрээ дэлхийн санхүүгийн дижитал шилжилтийг тэргүүлж байна. Хяналт, шалгалтын технологийн хувьд ч бүс нутгийн зарим зохицуулагч байгууллагууд суптек хөгжлийн дэлхийн чиг хандлагыг тодорхойлох түвшинд хүрээд байна.

Монгол Улсын хувьд санхүүгийн систем дэх инновац шийдэл, финтек болон төлбөрийн үйлчилгээний хөгжлөөр бүс нутгийн тэргүүлэгч орнуудтай эн зэрэгцэн хөгжиж байна. Гэвч энэхүү хөгжил нь шинэ төрлийн эрсдэл болон хяналт, шалгалтын шинэ сорилтуудыг дагуулж байгаа тул зохицуулагч байгууллагуудын уян хатан, өгөгдөлд суурилсан, инновацлаг хариу зохицуулалт зайлшгүй шаардлагатай юм.

Санхүүгийн залилан, кибер болон мэдээллийн аюулгүй байдал, технологийн ёс зүйтэй хэрэглээ, уур амьсгалын эрсдэл зэрэг шинэ асуудлууд нэмэгдэж буй өнөө үед санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь зөвхөн байгууллагын түвшинд хязгаарлагдах бус, нийт зах зээлийн тогтвортой байдал болон хэрэглэгч, хөрөнгө оруулагч, иргэдийн санхүүгийн эрх ашгийг хамгаалах чиглэлд илүү ухаалаг, технологид суурилсан арга барилд шилжих хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна.

### Эх сурвалж:

Энэхүү нийтлэл нь *Cambridge SupTech Lab*-ын блогт “*Shaping the Next Generation of Financial Supervision in APAC: Insights from SupTech Week 2024*” нэрээр анх нийтлэгдсэн нийтлэлийн орчуулж, шинэчлэн боловсруулсан хувилбар юм. Эх нийтлэлийг дараах холбоосоос унших боломжтой: <https://lab.ccaf.io/blog/shaping-the-next-generation-of-financial-supervision-in-apac-insights-from-suptech-week-2024/>

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ДААТГАЛЫН КОМПАНИД ХАНДАХ МЭДЭЭЛЭЛ



УИХ-аас 2025 оны 7 дугаар сард Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай болон Жолоочийн даатгалын тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Уг хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэгт зааснаар, жолоочийн даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, осолд холбогдсон жолооч нарын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгөд хохирол учраагүй, мөн жолооч нар хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч ослын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар хүлээн авч, нөхөн төлбөр олгох асуудлыг шуурхай шийдвэрлэх боломж бүрдэж байна.

Ингэснээр дээрх нөхцөлд жолооч нар цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргээс чөлөөлөгдөх бөгөөд ослын мэдээллийг цахимаар бүртгүүлж, даатгалын компанид шууд хандах боломжтой юм. Энэ нь ослын бүртгэл, нөхөн төлбөрийн үйл явцыг хялбаршуулж, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой шинэчлэл болж байна.

Иргэд, даатгуулагч та бүхэн жолоочийн даатгалын тохиолдол гарсан үед холбогдох даатгалын компанийн утасны дугаар болон цахим хаягийн мэдээллийг манай сайтаар зочилж үзнэ үү.

### "ГОВЬ" ХК-ИЙН ХЭЛБЭРЭЭ ӨӨРЧИЛЖ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛОХ АЖИЛЛАГААГ ЗОГСООЛОО



"Говь" ХК нь 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр хэлбэрээ өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болох шийдвэр гаргасантай холбогдуулж Санхүүгийн зохицуулах хорооноос газар дээрх хяналт шалгалтыг хийж, дараах зөрчлийг илрүүллээ.

2019 оны 5 дугаар сард "Говь" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн холбогдох шийдвэрүүдээр "Гоёо" ХХК-ийн хувьцааг "Таван Богд холдингс" ХХК-аас 15.0 сая ам.доллараар худалдан авах, мөн оны 7, 8 дугаар сард "Гоёо" ХХК-ийн 101.5 тэрбум төгрөгийн зээлийг "Говь" ХК-д шилжүүлэн авахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу "Говь" ХК нь 2019–2024 оны хооронд хувьцааны төлбөрт 17.7 сая ам.доллар, зээлийн төлбөрт 106.6 тэрбум төгрөг буюу нийт 161.7 тэрбум төгрөгийн төлбөрийг холбогдох банк, санхүүгийн байгууллагууд болон нэр бүхий компанид төлж барагдуулсан байна.

Дээрх шийдвэрүүдийг гаргахдаа "Гоёо" ХХК-ийн санхүү, үйл ажиллагаа, өр төлбөр, хөрөнгийн талаарх судалгаа тооцоололгүй, эд хөрөнгийн эрхийн буюу хувьцааны зах зээлийн үнийг тогтоолгүй, хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээ, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтгүйгээр хувьцааг худалдан авах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн ба "Гоёо" ХХК-ийг нэгтгэх шийдвэрийг гаргаагүй боловч охин компанийн зээлийг хариуцах, шилжүүлэн авах эрх зүйн болон бодит үндэслэлгүйгээр өрийг шилжүүлэн авч төлсөн нь хууль зөрчсөн байна. Хууль зөрчсөн эдгээр үйлдлээс шалтгаалан компанийн өр

төлбөр, санхүүжилтийн зардал нэмэгдэн сүүлийн 6 жилийн хугацаанд ашиггүй ажиллаж, ногдол ашиг олгох боломжгүй нөхцөл үүсч жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзлээ.

Монголын хөрөнгийн бирж дээр “Говь” ХК-ийн 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаарх зах зээлийн үнэлгээ 178.2 тэрбум төгрөг байгаа бол тус компанийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангаар 388.7 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна.

Өр төлбөрийн хүрээнд 2019 оноос хойш ноос, ноолуурын түүхий эд бэлтгэх, тэдгээртэй холбоотой бусад эргэлтийн хөрөнгийн зориулалт бүхий төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр нийт 228.3 тэрбум төгрөгийн зээл авснаас 31.8 хувь буюу 72.7 тэрбум төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан бол бусад зээлийн төлбөрийн зарцуулалт тодорхойгүй байна.

Иймд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, компанид учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулсны дараа хувьцааны бодит үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар дахин хийлгүүлэх зэрэг үүрэг даалгаврыг “Говь” ХК-д хүргүүлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар олгогдсон чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах шаардлагын дагуу эдгээр асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд буюу “Говь” ХК-ийн 10.3 хувийн хувьцааг эзэмшиж буй 25,000 гаруй жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашиг хамгаалагдах хүртэл тус компанийн хэлбэрээ өөрчлөх ажиллагааг зогсоолоо.

Жич: “Говь” ХК нь нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлийн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх үүрэгтэй.

“Говь” ХК-ийн хувьцааны арилжаа хөрөнгийн бирж дээр хэвийн үргэлжилж байгаа болно.

### **“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА 1072 ХУВЬЦАА” ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ БОЛЛОО**


Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй. Ийм ч учраас Санхүүгийн зохицуулах хороо иргэд, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, мэдлэг түгээх сургалт хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулсаар байна. Энэ хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран “Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөгийг Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймагт зохион байгууллаа.



Өдөрлөгөөр санхүүгийн залилан, луйврыг таньж, түүнээс урьдчилан сэргийлэх, хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголтын талаар сургалт зохион байгуулсан бөгөөд 5 аймгийн нийт 1,800 орчим иргэд, олон нийт идэвхтэй оролцож, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, ур чадварыг олж авлаа.

### **АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА**

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Шэннон Коулинтай өнөөдөр уулзлаа. Уулзалтын эхэнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга



Т.Жамбаажамц Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжилд Азийн хөгжлийн банкнаас үзүүлсэн үнэтэй хувь нэмэрт талархал илэрхийлээд бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлсэн онцлох ажлууд болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын өнөөгийн нөхцөл байдлынхаа талаар мэдээлэл өгсөн.

Харин Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Шэннон Коулин Монгол Улсад финтек салбарын зохицуулалтын орчныг хөгжүүлэх, мөн орон нутгийн иргэд, малчдын санхүүгийн хүртээмжийг

нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлынхаа талаар танилцуулсан юм. Тэрээр цаашид Санхүүгийн зохицуулах хороотой хамтын ажиллагаагаа өргөжүүлж, санхүүгийн салбарын хөгжил, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ.

Уулзалтын хүрээнд хоёр тал хадгаламж, зээлийн хоршооны салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх, орон нутгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд илүү нягт хамтран ажиллахаар тохиролцлоо.

Уулзалтад Азийн хөгжлийн банкны Улс хариуцсан ахлах эдийн засагч Мартино Пелли, Цаг уурын өөрчлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Энх-Амгалан болон холбогдох бусад төлөөлөл оролцсон юм.

## ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЖ ЦАН ЦОХИЛОО

“Си И Си Ая ассет ван ТЗК” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол өнөөдөр



боллоо. Цан цохих ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал М.Даваажаргал, “Си И Си инвестмент ББСБ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Х.Гиймаа, “Ти Ди Би секьюритис ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батчимэг болон холбогдох бусад хүмүүс оролцов. Тус компани олон нийтэд зориулан 24 сарын хугацаатай, жилийн 18.0 хувийн өгөөжтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30,000 ширхэг, 3.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг санал болгон гаргаж байна.

## САНХҮҮГИЙН ХУУЛЬ БУС ҮЙЛДЛЭЭС ИРГЭДИЙГ ХАМГААЛАХАД ЧИГЛЭСЭН ШИНЭ ШАТНЫ ХЯНАЛТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИНЭ

Сүүлийн жилүүдэд зохих зөвшөөрөлгүйгээр санхүүгийн үйлчилгээ үзүүлэх, иргэдийг залилсан санхүүгийн гэмт хэрэг нэмэгдэх болсон. Иймд Санхүүгийн зохицуулах хороо иргэд, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн ил тод, хариуцлагатай орчныг бүрдүүлэх, тэр дундаа орон нутагт хууль бус санхүүгийн үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон бүртгэлийн мэргэжилтнүүдэд улсын байцаагчийн эрх олгохоор шийдвэрлэлээ.

Ингэснээр санхүүгийн хяналтыг орон нутагт сайжруулж, иргэдийн эрх ашиг бодитойгоор хамгаалагдах, хууль бус үйл ажиллагаанд өртөх эрсдэлээс сэргийлэгдэх боломж бүрдэхийн зэрэгцээ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгчдийн хууль, эрх зүйн орчинд ажиллах, хариуцлага нэмэгдэх давуу талтай. Мөн иргэдэд зориулсан мэдээлэл, сэрэмжлүүлэг, сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа илүү хүртээмжтэй, бодитой болох, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, хөрөнгө оруулагчдын итгэл бэхжих давуу талтай.

Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран улсын байцаагчийн эрхтэй 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, бүртгэлийн мэргэжилтнүүдэд улсын байцаагчийн эрх зүйн байдал, зөрчлийн хэрэг маргаан болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой чиглүүлэх, мэдээлэл өгөх сургалт зохион байгууллаа. Ингэснээр эдгээр улсын байцаагч холбогдох хууль тогтоомж, хяналт шалгалт, гарсан зөрчлийг хууль зүйн үндэслэлтэй, үр дүнтэй хэрэгжүүлэх чадамжаар хангагдах, орон нутгийн түвшинд хууль бус санхүүгийн үйл ажиллагаатай шуурхай тэмцэх нөхцөл бүрдэх юм.



Санхүүгийн зохицуулах хороо цаашид ч улсын байцаагч нартай байнга хамтран ажиллаж, мэргэжлийн чадавхыг нь нэмэгдүүлэх, хууль бус санхүүгийн үйл ажиллагаатай тэмцэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

## ЯРИЛЦЛАГА

### ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ЧАДАВХ НЭМЭГДЭНЭ

*Даатгалын салбарын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нэг болох Даатгагчийн баталгааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболдтой ярилцлаа.*

**Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө, даатгагчийн баталгааны өнөөгийн нөхцөл байдлын талаар ярилцлагаа эхлүүлэе.**

Даатгагчийн баталгаа нь банкны баталгааны нэгэн адил үүргийн гүйцэтгэлийг хангуулах санхүүгийн чухал арга хэрэгслийн нэг юм. Аливаа гэрээний харилцаанд оролцож байгаа талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, үүний улмаас ихээхэн хэмжээний хохирол учрах эрсдэл өндөр байдаг тул учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, санхүүгийн аюулгүй байдлыг хангах, гэрээний талууд хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор баталгааг өргөнөөр ашигладаг.

Манай улсын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерт оролцогч нь тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа болон урьдчилгаа төлбөрийн баталгааг зөвхөн Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас, банкны баталгаагаар ирүүлэхээр тусгасан байсан. УИХ-аас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Даатгалын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу даатгагч нь холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах болсноор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах ажиллагаандаа даатгагчийн баталгааг ашиглах, худалдан авах ажиллагаанд шаардлагатай баталгааг олон эх үүсвэрээр гаргуулах, санхүүгийн хүндрэлийг эдийн засгийн үр өгөөжтэй, түргэн шуурхай арга хэлбэрээр шийдвэрлүүлэх боломж бүрдсэн.

Ийнхүү баталгаа гаргаж эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар даатгалын компаниуд нийт 113.7 тэрбум

төгрөгийн 1,264 баталгааг гаргаад байгаа бөгөөд цаашид даатгагчийн баталгааны эрэлт, хэрэгцээ улам нэмэгдэх хандлагатай байна.

**Та даатгагчийн баталгааны эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар дурдлаа. Ер нь баталгааны зах зээлийн хувьд ямар чиг хандлага ажиглагдаж байна вэ?**

Дүгнээд харвал хоёр чиглэл тод харагдаж байна. Нэгдүгээрт, төрийн худалдан авах ажиллагаанд даатгагчийн баталгааг ашиглах хэрэгцээ, итгэлцэл нэмэгдэж байна. Энэ нь төсөв, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төслийн эрсдэлийг бууруулах чухал алхам юм. Хоёрдугаарт, хувийн хэвшил дундах хэрэгцээ, соёл өөрчлөгдөж байна. Өмнө нь худалдан авах ажиллагаанд банкны баталгааг давамгайл хэрэглэдэг байсан бол одоо даатгагчийн баталгааны төлбөр, үйлчилгээний уян хатан нөхцөл нь даатгалыг илүүд үзэх хандлагад эерэг нөлөө үзүүлж байна. Нөгөө талаас, даатгалын компаниудын чадавх, эрсдэлийн үнэлгээ, нөхөн төлбөрийн бодлого, даатгалын хамгаалалт сайжирч байгаа нь зах зээлийг илүү найдвартай болгож байна.

**Монгол Улсад даатгагч баталгаа гаргах үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш салбарын хэмжээнд ямар асуудал тулгамдаж байна вэ?**

Холбогдох хуулиудад оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг зохицуулсан журмыг батлахдаа даатгалын компаниуд баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд санхүү, төлбөрийн чадварын хувьд ямар шаардлага тавигдах, хэдий хэмжээний баталгаа гаргаж болох зэрэг шаардлагуудыг тодорхой болгож өгсөн. Үүний дагуу даатгагч өөрийн хөрөнгө, санхүүгийн чадвар, эрсдэл

даах чадвартаа нийцүүлэн баталгаа гаргах шийдвэрийг гаргах бөгөөд бидний тооцоолсноор даатгалын компаниуд 80 орчим тэрбум төгрөгийн баталгаа гаргах боломжтой байна.

Гэтэл 2024 оны төрийн худалдан авах ажиллагааны статистик тоон мэдээллээс харахад нийт 450 орчим тэрбум төгрөгийн баталгаа гаргуулсан байх бөгөөд үүний 5 орчим хувийг даатгагч, үлдэх 95 орчим хувийг дотоодын болон гадаадын банкнаас гаргасан баталгаа эзэлж байгаа тоо мэдээ байна. Эндээс даатгагчийн оролцоо бага байгаа мэт харагдаж байгаа боловч өмнө дурдсанчлан даатгагчийн баталгааны эрэлт, хэрэгцээ хурдтай нэмэгдэж байгаа. Иймд даатгалын компаниуд энэхүү эрэлт, хэрэгцээг хангах чадавхтай байх нь хамгийн чухал байна.

Нөгөөтээгүүр, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа нь салбарт нэвтэрсэн шинэ үйлчилгээ, үйл ажиллагаа тул бидэнд баталгаатай холбоотой эрсдэлийг үнэлэх мэдээллийн сан, үйл ажиллагааны туршлага дутмаг байна. Мөн даатгагчийн гаргах баталгааны хэмжээ нэмэгдэхийн хэрээр өндөр дүнтэй гэрээний төлбөр төлөх шаардлагууд бий болж, даатгагчийн санхүүгийн чадавхад тодорхой хэмжээгээр дарамт үүсэх, тэдний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл нэмэгдэж болзошгүй байна.

Иймд цаашид даатгалын компаниудын баталгаа гаргах чадавх болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мөн учирч болох эрсдэлээс сэргийлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, түүний хяналтыг сайжруулах шаардлага үүсээд байна.

**Эдгээр тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ? Бодлого, зохицуулалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос ямар ажлуудыг авч хэрэгжүүлж байна вэ?**

Даатгалын компаниуд баталгаа гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах ажиллагаандаа даатгагчийн баталгааг ашиглаж эхэлснээр нэг талаас иргэд, аж ахуйн нэгжийн хувьд баталгааг олон эх үүсвэрээр гаргуулах боломжтой болсноос гадна нөгөө талаар даатгалын салбарын эрсдэлийн удирдлага, санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр нөлөөтэй байна. Иймд Санхүүгийн зохицуулах хороо нь даатгагчийн баталгааг амжилттай нутагшуулах чиглэлээр даатгалын салбарын

оролцогчидтой тухай бүр хамтран ажиллаж байна. Мөн даатгалын салбарын гаргаж буй баталгааны хэмжээг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, улмаар даатгалын салбарын нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор даатгагчийн баталгааны зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Тухайлбал, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаатай холбоотой практикт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд зохицуулалтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэх, давхар даатгал, хамтын даатгалын оролцоог дэмжих замаар даатгагчийн баталгаа гаргах чадавх, эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг холбогдох журамд тусгахаар ажиллаж байна. Мөн олон улсын туршлагад тулгуурлан даатгагчийн баталгаанд тавигдах санхүүгийн хяналтын механизм, ил тод байдал, харилцагчийн мэдээллийн хамгаалалт, эрсдэлийг бууруулах хяналт зэрэг чиглэлд бодлогын шинэчлэлүүд хийгдэж байна. Эдгээр алхмуудын зорилго нь зах зээлийг хязгаарлах биш, харин хариуцлагатай, итгэлцэлд суурилсан өрсөлдөөнийг дэмжих явдал бөгөөд энэхүү зохицуулалтын өөрчлөлтийг оруулснаар даатгалын компаниудын баталгаа гаргах чадавх нэмэгдэх боломж бүрдэнэ гэсэн тооцоололтой байна.

**Даатгагчийн баталгаатай холбоотойгоор цаг гарган ярилцсан танд баярлалаа.**

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухаан нь хүн төрөлхтний амьдралын бүх салбарт нэвтэрч, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжилд хүчтэй түлхэц өгч байна. Гэвч хиймэл оюун ухааны системийн хөгжүүлэлт болон хэрэглээнд зарцуулагдаж буй эрчим хүч, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаралт нь байгаль орчинд ноцтой нөлөө үзүүлж эхэлжээ. Иймээс “Green AI” буюу ногоон хиймэл оюун ухаан гэх ойлголт бий болж, хиймэл оюун ухааны хөгжлийг тогтвортой байдлын зарчим нийцүүлэх шинэ чиг хандлага бий болсон.

Ногоон хиймэл оюун ухаан хэмээх нэр томъёог анх 2019 онд Шварц, Додж, Смит болон Этциони нар “Communications of the ACM” сэтгүүлд танилцуулсан. Хиймэл оюун ухааны томоохон төлөөллүүд болох ChatGPT, Gemini зэрэг системүүд нь асар их хэмжээний дата боловсруулалт болон тооцоолол шаарддаг. Үүний үр дүнд цахилгаан эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэж, улмаар нүүрстөрөгчийн ул мөр (carbon footprint) ихэсдэг байна. Жишээ нь GPT-3-ыг хөгжүүлэхэд ойролцоогоор 550 тонн нүүрстөрөгчийн давхар исэл ялгарсан гэж OpenAI тооцоолсон. Энэ нь дунд зэргийн хэмжээтэй онгоц 125 удаа АНУ-Европын хооронд нисэхэд гарах ялгаралтай тэнцдэг. GPT-5 нь илүү том загвар тул үүнээс ч их энерги хэрэглэдэг гэж судлаачид үзэж байна. Харин ногоон хиймэл оюун ухааны гол зорилго нь энэ хэрэглээг бууруулахын тулд илүү үр ашигтай алгоритм боловсруулж, хөнгөн, эрчим хүчний хэмнэлттэй загваруудыг хөгжүүлэх, мөн сэргээгдэх эрчим хүч ашигладаг дата төвүүдийг нэвтрүүлэх юм.

өгөгдлийн боловсруулалтын эрэлт эрчимтэй нэмэгдэж буйг харуулж байна. Судалгаагаар уг хэрэглээ 2024 – 2030 он хүртэл жил бүр дунджаар 15 орчим хувиар өсөж 2030 он гэхэд нийт хэрэглээ 945 TWh буюу өнөөгийн түвшнээс хоёр дахин нэмэгдэж дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээний 3 орчим хувийг эзлэх төлөвтэй байна. Энэ нь бусад салбаруудын цахилгаан хэрэглээний өсөлтөөс дөрөв дахин өндөр үзүүлэлт ажээ.

Тогтвортой санхүүжилтийн гол зорилго нь эдийн засгийн өсөлтийг байгаль орчин, нийгмийн хариуцлагатай байдлын хамт хангах явдал юм. Энэ хүрээнд Ногоон хиймэл оюун ухаан нь дараах гурван үндсэн чиглэлд хувь нэмэр оруулж байна:

- ◆ Финтек: Санхүүгийн байгууллагууд хиймэл оюун ухаан ашиглан өгөгдлийг боловсруулахдаа бага эрчим хүч хэрэглэдэг алгоритмуудыг ашигласнаар ногоон эдийн засагт шилжих үйл явцаа урагшлуулах боломжтой.
- ◆ ESG өгөгдлийн шинжилгээ ба ил тод байдал: AI технологи нь ESG (Environmental, Social, Governance)-ийн мэдээллийг боловсруулж, илүү нарийн дүн шинжилгээ хийх боломж олгодог. Ногоон хиймэл оюун ухаан нь үүнийг байгальд ээлтэй байдлаар гүйцэтгэхийг зорьдог.
- ◆ Карбон хяналт ба тогтвортой хөрөнгө оруулалт: Ногоон хиймэл оюун ухаан нь байгууллагуудын нүүрстөрөгчийн ялгарлыг тооцоолох, бууруулах стратегийг зөвхөн технологийн хөгжилд төдийгүй эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх болсон байна.

Монгол Улсад финтек салбарт хиймэл оюун ухаанд суурилсан технологийн хэрэглээ нэмэгдэж байна. Тухайлбал, AND Global компанийн охин компани болох AND Solutions нь хиймэл оюун ухаанд суурилсан технологийн шийдлээ Microsoft Azure үүлэн платформд амжилттай нэвтрүүлж, Microsoft AI Partners-ийн нэг болсон нь энэ чиглэлд гарч буй томоохон дэвшлийн нэг юм. Нөгөө талаар, Google, Microsoft, Amazon зэрэг дэлхийн тэргүүлэх байгууллагууд өөрсдийн дата төвүүдийг сэргээгдэх эрчим хүчээр ажиллуулж, ногоон хиймэл оюун ухааныг бодит амьдралд хэрэгжүүлж, эрчим



Олон Улсын Эрчим Хүчний Агентлагийн (IEA) 2024 оны тайланд дурдсанаар, дэлхий даяарх дата төвүүдийн цахилгаан хэрэглээ ойролцоогоор 415 тэрбум кВт.цаг (TWh)-т хүрсэн бөгөөд энэ нь хиймэл оюун ухааны тооцоолол болон

хүчний хэрэглээг бууруулахад анхаарч байна. Иймээс Монголын санхүүгийн байгууллагууд ч мөн адил ногоон хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх, технологийн шийдлээ тогтвортой хөгжлийн зарчимтай уялдуулах алхмуудыг эхлүүлж байна гэж хэлж болно. Үүнээс гадна, олон улсын туршлагаас харахад хиймэл оюун ухааныг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаанд өргөнөөр ашиглаж эхэлжээ. Тухайлбал, Rachata компани хиймэл оюун ухааныг ашиглан ойн нөхөн сэргээлт болон нүүрстөрөгчийн бууралтыг тооцох систем хөгжүүлж байгаа бол ClimaTiq байгууллага хиймэл оюун ухаанд суурилсан нүүрстөрөгчийн ялгарлын ил тод тооцооллын шийдэл санал болгож байна.

Мөн эдгээр санаачилга нь технологийг байгаль орчинд ээлтэй байдлаар ашиглах, ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит шийдэл гаргах чиглэлд чухал хувь нэмэр оруулж байна.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP) болон OECD-ийн “Sustainable AI” санаачилга нь технологийн салбарын тогтвортой хөгжлийг бодлогоор дэмжихийг уриалж байна. Түүнчлэн тогтвортой санхүүгийн байгууллагууд ногоон хиймэл оюун ухааны зарчмыг нэвтрүүлснээр зөвхөн байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх бус, зардал бууруулах, хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэх шинэ боломжуудыг бий болгож байна.

Гэвч ногоон хиймэл оюун ухааны хөгжлийн явцад хэд хэдэн сорилт тулгарч байгаа бөгөөд тэдгээрийн нэг нь дата боловсруулах болон хадгалах үйл ажиллагаа ихэвчлэн гадаад серверүүд болон төвлөрсөн дата төвүүдэд төвлөрдөг явдал юм. Ийм төвлөрсөн бүтэц нь эрчим хүчний хэрэглээг тодорхой бүс нутагт хэт төвлөрүүлж, ногоон зарчимтай нийцүүлэхэд хүндрэл учруулдаг төдийгүй байгаль орчны нөлөөллийг бодит цаг хугацаанд үнэлэх боломжийг хязгаарладаг. Хиймэл оюун ухааны хөгжүүлэлт болон хэрэглээнд ашиглагддаг GPU, CPU зэрэг төхөөрөмжүүд маш их эрчим хүч хэрэглэдэг бөгөөд, богино настай



байдаг учир электрон хог хаягдал үүсгэдэг. Энэ нь бодит ногоон үр дүнг бууруулж байгаа тул эрчим хүч хэмнэлттэй, дахин ашиглах боломжтой төхөөрөмжийг нэвтрүүлэх шаардлагатай.

Ногоон хиймэл оюун ухаан нь технологийн дэвшил ба тогтвортой хөгжлийн зааг дээр бий болж буй шинэлэг хандлага юм. Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, ил тод бөгөөд ёс зүйтэй хэрэглээг дэмжих замаар энэ чиглэл нь дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүчтэй түлхэц өгч байна. Ийнхүү ногоон хиймэл оюун

ухаан нь зөвхөн технологийн хөгжилд төдийгүй тогтвортой санхүүгийн экосистемийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх түлхүүр хэрэгсэл болон төлөвшиж байна.

### Эх сурвалж:

- ◆ Schwartz, R., Dodge, J., Smith, N. A., & Etzioni, O. (2019). *Green AI. Communications of the ACM.* <https://dl.acm.org/doi/pdf/10.1145/3381831>
- ◆ OECD AI Policy Observatory. (2024). *Sustainable AI and Environmental Impact. Organisation for Economic Co-operation and Development.* <https://oecd.ai/en/themes/sustainable-ai>
- ◆ International Energy Agency (IEA). (2024). *Energy demand from AI.* <https://www.iea.org/reports/energy-and-ai/energy-demand-from-ai>
- ◆ AND Global. (2024). *AND Global becomes one of the first Mongolian AI partners to Microsoft with Mindox now live on Microsoft Azure.* <https://and.global/and-global-becomes-one-of-the-first-mongolian-ai-partners-to-microsoft-with-mindox-now-live-on-microsoft-azure>
- ◆ Organisation for Economic Co-operation and Development (OECD). (2022). *Measuring the environmental impacts of artificial intelligence compute and applications: The AI footprint.* [https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2022/11/measuring-the-environmental-impacts-of-artificial-intelligence-compute-and-applications\\_3ddddd5/7babf571-en.pdf](https://www.oecd.org/content/dam/oecd/en/publications/reports/2022/11/measuring-the-environmental-impacts-of-artificial-intelligence-compute-and-applications_3ddddd5/7babf571-en.pdf)

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## ISO 37301 НИЙЦЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

Эхлэл нь 1-р нүүрт

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.4.1-д “Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплайнсын шаардлагыг хангах зорилгоор ‘Комплайнсын менежментийн тогтолцоо ISO 37301’ стандартыг хувийн хэвшилд нэвтрүүлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаагаар хангах”-аар заажээ. Компаниудад “нийцлийн менежментийн тогтолцоо”-г бүрдүүлэх хамгийн шалгарсан арга бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO 37301 стандартыг сурталчлан таниулах явдал байдаг аж.

Олон улсын стандартчиллын байгууллага нь “ISO 37301 Нийцлийн менежментийн тогтолцоо”-г 2021 оны 4 дүгээр сард батлан гаргасан. Энэхүү баримт бичигт байгууллагуудад нийцлийн менежментийн тогтолцоог бий болгох, хөгжүүлэх, мөрдүүлэх, үнэлэх, засан сайжруулахад тавигдах шаардлага болон хэрэгжүүлэх арга зүйн зааврыг багтаажээ. Уг стандарт нь 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын дотоодын стандарт болж батлагдсан байна.

**“ISO 37301 Нийцлийн менежментийн тогтолцоо”-ны баримт бичиг нь дараах агуулга бүхий бүлгүүдээс бүрддэг. Үүнд:**

- ⇒ Байгууллагын тухай ойлголт;
- ⇒ Байгууллагын нөхцөл байдал;
- ⇒ Манлайлал;
- ⇒ Нийцлийн зорилтод хүрэх төлөвлөлт;
- ⇒ Нийцлийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах асуудлууд;
- ⇒ Нийцлийн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавих;
- ⇒ Хэрэгжилтийг үнэлэх;
- ⇒ Эргэх холбоо буюу сайжруулалт зэрэг болно.

Энэхүү стандартыг хэрэгжүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ISO 37001 стандартыг нэвтрүүлснийг итгэмжлэн гэрчилгээ олгодог. Тэгвэл энэхүү стандартыг нэвтрүүлэх нь яагаад чухал вэ? Бизнесийн байгууллагууд төрөөс баталсан хууль тогтоомж, дүрэм журам, бусад шаардлага үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллах нь зохион байгуулалт, арга зүй, байнгын хяналт шинжилгээг шаарддаг онцлогтой билээ. ISO 37301 стандартыг компанидаа нэвтрүүлж, гэрчилгээ авсан байгууллагын хувьд дээр дурдсан үйл ажиллагаанууд ихээхэн хөнгөвчлөгддөг. Энэ нь компанийг хууль тогтоомж, дүрэм журам, салбарт мөрдөгддөг заавар, стандартуудыг бүрэн хангаж ажилладаг болохыг гадаад орчинд сурталчлан

харуулж, компанийн дотоодод буюу ТУЗ, удирдлага, бусад ажилтнуудын дунд бизнесийн үйл ажиллагаа нь ямар нэгэн эрсдэл, үйл ажиллагааны доголдол, сааталгүйгээр явагдах итгэл үнэмшлийг бий болгодог байна.

Түүнчлэн, ISO 37301 нь олон улсад нийцлийн менежментийн тогтолцооны жишиг болдог тул гадаад улсын хөрөнгө оруулагчдыг татах, нийцлийн менежментийн тогтолцоог нэвтрүүлээгүй компаниудтай зах зээлд өрсөлдөхөд давуу байдлыг бий болгож байна.

**ISO 37301 стандарт нэвтрүүлж, гэрчилгээ авах үе шат дараах байдлаар явагддаг. Үүнд:**

- ◆ Анхан шатны уулзалт хийх. ISO 37301 стандартын гэрчилгээг олгох аудитын компани болон уг стандартаар гэрчилгээ авахыг хүссэн байгууллагын хооронд танилцах уулзалт болж, гэрчилгээ олгох үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцоно.
- ◆ Аудитыг гүйцэтгэх. Энэ үе шатанд аудитын компани болон хүсэлт гаргагч байгууллагын “нийцлийн менежментийн тогтолцоо”-г бүрдүүлэх чиглэлээр ажилласан байдал, энэ чиглэлээрх компанийн дотооддоо баталсан бодлого, дүрэм журам, нөхцөл байдал, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлдэг. Ихэнх аудитын компаниуд энэ үе шатыг хоёр дэд үе шатанд хувааж гүйцэтгэдэг.
- ◆ Аудитын тайлан гаргах. Аудитын компани нь хийсэн үнэлгээ, дүгнэлтээ үндэслэн тухайн байгууллагад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO 37301 стандартыг нэвтрүүлснийг батламжилсан гэрчилгээг олгох эсэх шийдвэрийг гаргадаг.
- ◆ Хяналтын аудит хийх. Аудитын компани нь ISO 37301 стандартын гэрчилгээг авсан байгууллагад хяналтын аудитыг ихэнхдээ жилд нэг удаа хийж, уг стандартын шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхийг шалгадаг.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ISO 37301 стандартыг хувийн хэвшлийнхэн, бусад байгууллагуудад таниулан сурталчлах ажил үе шаттай хэрэгжиж байгаа бөгөөд уг стандартыг компанидаа нэвтрүүлэн хэрэгжүүлэх эсэх нь тухайн компанийн удирдлагын хүсэл зоригийн асуудал юм. Гэвч бизнесээ нэг шат ахиулж, бусад компаниудаас ялгарах, гадаадын болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх эрмэлзэлтэй бизнес эрхлэгчийн хувьд хийж болох хамгийн зөв сонголтуудын нэг бол ISO 37301 стандарт мөн билээ.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### СТЕЙБЛКОЙН: ТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХӨРӨНГӨ

Цахим валютын зах зээлд хурдацтай өсөж буй чиглэлийн нэг нь стейблкойн (stablecoin) юм. Түүний зах зээлийн хэмжээ хязгаарлагдмал байгаа ч хурдацтай өсөлт нь дэлхийн зохицуулагчдын анхаарлыг татаж байна.

#### СТЕЙБЛКОЙН БА ТҮҮНИЙ ТӨРӨЛ



Стейблкойн гэдэг нь хэлбэлзэл багатай, үнэ тогтвортой дижитал хөрөнгө (digital asset) юм. Тус хөрөнгийн онцлог нь тогтвортой байдал бөгөөд уламжлалт криптовалюта (жишээ нь: биткойн) шиг үнийн савлагаа, тогтвортой бус байдлыг үүсгэдэггүй байна.

**Стейблкойн нь зорилго, бүтцээс хамаарч гол төлөв дараах хоёр төрөлд хуваагддаг:**

- ◆ Төлбөрийн стейблкойн (Payment stablecoin): Энэ төрлийн стейблкойн нь зөвхөн үнийг тогтвортой байлгах үүрэгтэй бөгөөд ихэвчлэн бэлэн мөнгө эсвэл богино хугацааны эрсдэл багатай хөрөнгөөр баталгаажсан байдаг. Төлбөрийн стейблкойн нь ихэвчлэн төлбөр, арилжаа, гүйлгээний хэрэгсэл болж ашиглагддаг. Жишээ нь, USDC (Circle), USDT (Tether).
- ◆ Өгөөж олгох стейблкойн (Yield-bearing stablecoin): Энэ төрлийн стейблкойны хувьд эзэмшигчдэд шууд өгөөж (on-chain return) олгох бүтэцтэй байдаг. Өөрөөр хэлбэл, төлбөрийн стейблкойн (USDC, USDT гэх мэт) дээр суурилж, зуучлагч платформ (бирж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч) ашиглан хөрөнгө оруулалт хийх, бусдад зээлдүүлэх, эсхүл бусад өгөөж олгох аргуудыг хэрэгжүүлдэг. Жишээ нь, Ethena-ийн sUSDe, Sky-ийн sUSDS, BlackRock-ийн BUIDL гэх мэт.

#### СТЕЙБЛКОЙНЫ ЗАХ ЗЭЭЛ



Стейблкойны нийт зах зээлийн үнэлгээ 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 280 тэрбум ам.доллараас давсан бөгөөд зарим судалгаагаар 2030 он гэхэд 1.9 их наяд ам.долларт хүрнэ гэж таамаглаж байна. Стейблкойн нь дэлхийн крипто зах зээлийн гол хөдөлгөгч хүчний нэг болж, АНУ-ын (Circle) компанийн гаргасан USDC болон Tether компанийн USDT нь нийт нийлүүлэлтийн дийлэнх хувийг эзэлж байна.

**Стейблкойн зах зээлийн гол үйл ажиллагаа:**

- ◆ Арилжаа ба төлбөр: Стейблкойн нь крипто биржүүд болон төлбөрийн системд ашиглагддаг бөгөөд өдөр тутмын гүйлгээ, худалдан авалт хийхэд тохиромжтой.
- ◆ Нөөц хөрөнгөөс орлого олох: Төлбөрийн стейблкойн гаргах зөвшөөрөлтэй этгээдүүд өөрсдийн нөөц хөрөнгөөс (жишээ нь бэлэн мөнгө, богино хугацааны Засгийн газрын үнэт цаас) орлого олох боломжтой. Энэ нь тус стейблкойн гаргах зөвшөөрөлтэй этгээдүүдэд шууд ашиг авах боломжийг бий болгодог.
- ◆ Зуучлагчийн платформ дахь өгөөжийн үйл ажиллагаа: Зарим платформууд (жишээ нь: Gemini Earn, Bitfinex margin lending) хэрэглэгчдэд стейблкойныг хадгалах, зээлдүүлэх, арилжаанд ашиглах замаар өөрийн хөрөнгөөс орлого олох боломжийг олгож байна. Гэхдээ хэрэглэгч нь эдгээр платформд стейблкойн байршуулсан тохиолдолд эрсдэл нь платформын ашиглалтын нөхцөлөөс хамаардаг.

## СТЕЙБЛОЙНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ХАНДЛАГА

Стейблкойны зах зээлийн хурдтай өсөлт нь дэлхийн улс орнуудыг зохицуулалтын шинэ арга хэмжээ авахад хүргэж байна.



### 1. Европын холбоо (ЕХ)

Европын холбоо нь 2024 онд Крипто хөрөнгийн зах зээлд чиглэсэн зохицуулалтын журам (Markets in Crypto-Assets Regulation, MiCA)–ыг баталсан бөгөөд энэ нь стейблкойн болон бусад крипто хөрөнгийн зохицуулалтын үндсэн баримт бичиг болсон. Энэхүү журмын гол зорилго нь шинэ технологи, санаачилгыг дэмжих, хэрэглэгчийг хамгаалах, зах зээлийн шударга өрсөлдөөн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм.

Тус журмын дагуу стейблкойныг дараах байдлаар ангилдаг:

- ◆ *Цахим мөнгөний токен (Electronic Money Token, EMT):* Нэг төрлийн мөнгөн тэмдэгттэй уялдсан, үнэ тогтвортой хадгалах зорилготой.
- ◆ *Хөрөнгөд үндэслэсэн токен (Asset-Referenced Token, ART):* Ханш тогтвортой байлгах зорилготой ч, тухайн токен нь бусад хөрөнгө, хөрөнгийн эрхтэй холбоотой байж болно.

Түүнчлэн энэхүү журмаар төлбөрийн стейблкойн гаргагчид нь эзэмшигчдэд шууд хүү, өгөөж олгохыг хориглодог явдал бөгөөд энэ нь гаргагчдаас гадна гуравдагч этгээдээр дамжуулан өгөөж олгох боломжийг ч хязгаарладаг. Мөн зуучлагч платформууд (CASP)–ын үйл ажиллагааг зохицуулдаг бөгөөд CASP нь стейблкойн эзэмшигчдэд шууд хүү төлөх боломжгүй байдаг.



### 2. Хонгконг Улсын зохицуулалт

Хонгконг Улс нь 2025 оны 5 дугаар сард Стейблкойны тухай журам (Stablecoins Ordinance, SO)–ыг баталсан бөгөөд энэхүү журмаар стейблкойныг гаргах, санал болгох, маркетинг хийх харилцааг зохицуулдаг. Тус журмын гол зорилго нь дижитал хөрөнгийн үйл ажиллагаанд зохицуулалт бий болгох, мөнгөний болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Хонконгийг олон улсын санхүүгийн төв болгон бэхжүүлэх явдал юм.

Стейблкойны тухай журмын дагуу:

- ◆ Фиат валютад суурилсан стейблкойн (FRS) гаргах зөвшөөрөлтэй этгээд нь тухайн токены эзэмшигчдэд ямар нэгэн хэлбэрийн хүү, өгөөж, эсхүл орлогоос хуваарилалт хийхийг хориглодог.
- ◆ Зуучлагч платформууд буюу виртуал хөрөнгийн арилжаа, хадгалалтын үйлчилгээ үзүүлэгчид (VATP)–ээс хэрэглэгчдэд шууд өгөөж олгохыг мөн адил хориглодог.
- ◆ Хонконгийн дээрх зохицуулалтын дагуу зөвхөн зөвшөөрөлтэй этгээдүүд, банк, лицензтэй хадгалалтын үйлчилгээ үзүүлэгч зэрэг байгууллагууд нь стейблкойны үйл ажиллагааг явуулах эрхтэй байдаг.



### 3. Сингапур Цлсын зохицуулалт

Сингапур Цлсын Санхүүгийн зохицуулах байгууллага (Monetary Authority of Singapore, MAS) 2023 онд нэг валюттай стейблкойн (Single-Currency Stablecoin, SCS)–д зориулсан зохицуулалтыг баталсан.

- ◆ Энэхүү зохицуулалт нь Сингапурын доллар эсвэл G10 валюттай уялдсан стейблкойныг зохицуулдаг.
- ◆ Стейблкойн гаргах зөвшөөрөлтэй этгээдүүд нь зөвхөн стейблкойн гаргах үйл ажиллагаанд төвлөрөх ёстой бөгөөд шууд хүү олгох, зээлдүүлэх, болон бусад бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хязгаарласан.
- ◆ Стейблкойныг арилжих, солилцох зуучлагч байгууллагууд (DPT үйлчилгээ үзүүлэгчид) зөвхөн зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх эрхтэй бөгөөд бусад улсын адилаар хэрэглэгчдэд хүү, урамшуулал өгөхийг хориглодог. Гэхдээ зарим тохиолдолд зохицуулагчийн тогтоосон шаардлага, хязгаарлалтын дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагчдад өгөөж санал болгох боломжтой байдаг



#### 4. АНУ-ын зохицуулалт

АНУ 2025 оны 7 дугаар сард “Төлбөрийн стейблкойны тухай хуулийн удирдамж ба үндэсний инновацийг тогтоох тухай хууль” (GENIUS Act)-ийг баталж, стейблкойны анхны цогц зохицуулалтын хүрээг бий болгосон.

- ◆ Төлбөрийн стейблкойн (Payment Stablecoin) гэдэг нь төлбөр болон гүйлгээ хийхэд зориулагдсан, ханшийг тогтвортой хадгалах үүрэгтэй дижитал хөрөнгө гэж тодорхойлсон.
- ◆ Стейблкойн гаргах зөвшөөрөлтэй этгээдүүд нь эзэмшигчдэд ямар ч хүү, өгөөж олгох боломжгүй. Энэ хориг нь дотоод болон гадаадын стейблкойн гаргагчдын аль алинд нь үйлчилдэг.
- ◆ Энэхүү хуулиар зуучлагч платформуудад (CASP) шууд хориг тавиагүй боловч энэхүү платформын үйл ажиллагааг хянах, зохицуулах чиглэлд холбогдох дүрэм гаргах үүрэг өгсөн.
- ◆ Зуучлагч платформуудын эрх зүйн зохицуулалт нь тэдний үйл ажиллагааны төрөл болон холбогдох крипто хөрөнгө, үйлчилгээний ангиллаас хамааран ялгаатай байдаг. Жишээлбэл, хадгалалт болон ...

#### ДҮГНЭЛТ

Стейблкойн нь цахим валют ба хөрөнгө оруулалтын шинжийг агуулсан шинэ төрлийн санхүүгийн хэрэгсэл бөгөөд төлбөрийн системд шинэ боломжуудыг нээж байгаа ч нөгөө талаас зохицуулагчдад шинэ сорилтуудыг үүсгэж байна.

Дээрх улс орнууд (Европын холбоо, АНУ, Сингапур, Хонконг)-ын зохицуулалт нь зөвхөн төлбөрийн зориулалттай буюу гүйлгээ, төлбөр тооцоонд ашиглагддаг стейблкойнуудад хамаарах бөгөөд зохицуулалтын нийтлэг онцлог нь стейблкойныг гаргах зөвшөөрөлтэй этгээдүүдийг стейблкойн эзэмшигчдэд хүү, өгөөж олгохыг хориглож байна. Харин өгөөжтэй буюу орлого бий болгодог стейблкойн нь эдгээр орнуудын хуулиар инновацийн шинжтэй, хөрөнгө оруулалтын зориулалттай бүтээгдэхүүн гэж тооцогддог бөгөөд тэдгээр нь төвлөрөөгүй санхүү (decentralized finance)-гийн хүрээнд тусгай зохицуулалтаар хэрэгждэг.

#### ЭХ СУРВАЛЖ

BIS (Bank for International Settlements). Stablecoins: market developments and regulatory perspectives. 2025.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### КАРБОН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хороо, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Д.Хулан /khulan@frc.mn /

#### ХУРААНГУЙ

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчин, эдийн засаг, нийгэмд хүчтэй нөлөө үзүүлж байгаа тул хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор олон улс карбон зах зээлийг хөгжүүлж байна. Карбон зах зээл нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эдийн засгийн хэрэгсэл бөгөөд карбон кредитийг арилжаалж, уур амьсгалын зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Карбон кредит нь нэг тонн CO<sub>2</sub>-ийг бууруулсан байдлыг илэрхийлдэг нэгж юм. Карбон зах зээлийг олон улсын болон дотоодын, мөн зайлшгүй дагаж мөрдөх (compliance) ба сайн дурын (voluntary) гэж ангилна. Олон улсын зах зээл нь Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд суурилсан бөгөөд улс орнууд хамтран хүлэмжийн хий бууруулсан үр дүнг (ТМО) арилжаалах боломжтой бол дотоодын зах зээл нь тухайн улсын хууль, бодлогод нийцсэн зах зээл юм. Карбон кредит үүсгэх механизм нь cap-and-trade (дээд хязгаар тогтоох арилжаа), baseline-and-credit (суурь түвшинд тулгуурласан кредит), нүүрстөрөгчийн татвар гэсэн хэлбэртэй.

#### УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт сөрөг нөлөө үзүүлж буй тул хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь дэлхийн улс орнуудын тэргүүний зорилтуудын нэг болж байна. Иймд улс орнууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд олон талт бодлого, эдийн засгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж эхэлсэн. Хүлэмжийн хийг эдийн засгийн үнэлэмж бүхий арилжааны нэгж болгон арилжих карбон зах зээл нь тогтвортой хөгжил, уур амьсгалын зорилтыг дэмжихэд чухал үүрэгтэй.

Карбон гэдэг нь нүүрстөрөгчийн давхар ислийн (CO<sub>2</sub>) болон бусад хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих нэгж юм. Харин эдгээр ялгарлыг бууруулах зорилгоор эдийн засгийн эргэлтэд оруулж буй механизмыг карбон кредит гэх ба нэг карбон кредит нь нэг тонн CO<sub>2</sub> эквивалент хэмжээний ялгарлыг бууруулсан байдлыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, байгаль орчны үр нөлөөг санхүүгийн нэгж болгон хөрвүүлснээр зах зээлд оролцогч талууд уур амьсгалын хариуцлагатай үйл ажиллагаа явуулах эдийн засгийн урамшуулал авах боломж бүрддэг. Дээр дурдсанчлан карбон зах зээл нь энэхүү кредитийг арилжаалах, баталгаажуулах, үнэ тогтоох тодорхой процесс бүхий эдийн засгийн орон зай бөгөөд үүнийг олон улсын болон дотоодын зах зээл гэж газар зүйн хамрах хүрээгээр, мөн хэрэгжих хэлбэрээр нь зайлшгүй дагаж мөрдөх (compliance market) ба сайн дурын (voluntary market) зах зээл гэж ангилдаг. Карбон кредитийн үнэ, эрэлт, нийлүүлэлт нь тухайн төслийн гарал үүсэл, баталгаажсан стандарт (Жишээ нь: Gold Standard, Verra), улс орны бодлого, зах зээлийн зохицуулалтаас шалтгаалан өөрчлөгддөг байна.

## КАРБОН ЗАХ ЗЭЭЛ, ТҮҮНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Карбон зах зээлийн суурь эрх зүйн орчин нь 1992 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC) батлагдсанаар бүрдсэн. Тус конвенц нь хүлэмжийн хийн ялгарлын улмаас үүсэх дэлхийн дулаарлын асуудлыг олон улсын түвшинд анх удаа хүлээн зөвшөөрч, улс орнууд хамтран ажиллах суурь зарчим, зорилгыг тодорхойлсон (UNFCCC, 1992). Уг конвенцын үргэлжлэл болгон 1997 онд Японы Киото хотноо болсон UNFCCC-ийн Оролцогч Талуудын 3 дугаар бага хурлаар Киотогийн протокол батлагдсан. Энэхүү протокол нь аж үйлдвэржсэн 37 улс оронд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2008–2012 он хүртэл нийт 5.2 хувиар бууруулах эрх зүйн үүрэг хүлээлгэж, анхны тоон зорилтыг олон улсын түвшинд хуульчлан тогтоосон. 2015 онд Парис хотод зохион байгуулагдсан UNFCCC-ийн Оролцогч талуудын 21 дүгээр бага хурлаар Парисын хэлэлцээр батлагдаж, дэлхийн 196 улс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эрх зүйн үүрэг бүхий анхны өргөн хүрээтэй хэлэлцээрт нэгдсэн. Тус хэлэлцээрийн хүрээнд улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх түвшинтэй харьцуулахад 2°C-аас доош, цаашлаад 1.5°C-д хязгаарлах зорилт тавьсан бөгөөд үүний хэрэгжилтийг хангахын тулд Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ таван жил тутам шинэчилж, шат дараатайгаар нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн (IPCC, 2018).

Зураг. Карбон зах зээлийн үүсэл, хөгжил




## КАРБОН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ

Карбон зах зээлийг газар зүйн байршлаар нь олон улсын болон дотоодын зах зээл хэмээн ангилдаг. Олон улсын зах зээлд улс орнууд хоорондын хамтын ажиллагаа, хэлэлцээрт тулгуурлан хил дамнасан карбон кредитийн арилжаа явагддаг бол дотоодын зах зээлд тухайн улсын хэмжээнд хэрэгжиж буй дотоодын хууль, бодлоготой уялдсан зохицуулалттай арилжаа хийгддэг.

Мөн түүнчлэн, Парисын хэлэлцээр, Европын Холбоо болон бусад бүс нутгийн зохицуулагчид хүлэмжийн хийн бууралтыг арилжаалах нэгжүүдийг өөр өөр нэршлээр нэрлэдэг. Жишээлбэл, ITMO, A6.4ER, EUA, TVER зэрэг нь нэршлээрээ ялгаатай боловч үндсэн агуулгаараа баталгаажсан хүлэмжийн хийн бууралтыг илэрхийлсэн "карбон кредит"-ийн нийтлэг ойлголтод хамаарна.

Зураг. Карбон зах зээлийн бүтэц



Эх сурвалж. Asian development bank

## ОЛОН УЛСЫН КАРБОН ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын карбон зах зээлийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааны үр нөлөөг олон улсын түвшинд нэмэгдүүлж, улс орнуудын хамтын ажиллагааг үр ашигтай зохицуулахад чиглэгддэг. Энэ зах зээлийн онцлог нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулсан үр дүнг улс хооронд шилжүүлэх, тооцох, баталгаажуулах тусгай журам, хяналтын системтэй. Мөн давхар тооцооллоос сэргийлэх, ил тод байдлыг хангах, үр дүнгийн найдвартай байдлыг баталгаажуулах зорилго бүхий аргачлал, тайлагналын шаардлагыг агуулдаг. Тиймээс олон улсын карбон зах зээл нь Парисын хэлэлцээр болон түүнийг дагалдах олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд суурилдаг.

Олон улсын карбон зах зээлийг эрх зүйн зохицуулалтын хувьд зайлшгүй дагаж мөрдөх зах зээл болон сайн дурын зах зээл гэж хуваадаг. Зайлшгүй дагаж мөрдөх карбон зах зээл нь олон улсын болон үндэсний хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд ажилладаг. Үүнд оролцогчид нь тогтоосон ялгаруулалтын хязгаарлалтыг дагаж, зөвшөөрлийн дагуу хүлэмжийн хий ялгаруулах үүрэгтэй байдаг. Сайн дурын нүүрстөрөгчийн зах зээлд байгууллага, хот, бүс нутаг өөрсдийн санаачилгаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулж, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор оролцдог. Энэ нь албан ёсны үүрэг хариуцлага хүлээдэггүйгээрээ зайлшгүй дагаж мөрдөх зах зээлээс ялгаатай юм. Сайн дурын зах зээлд оролцогчид мод тарих, сэргээгдэх эрчим хүч ашиглах, хөрсний менежмент сайжруулах зэрэг уур амьсгалд эерэг нөлөө үзүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт хийж, тухайн төслөөс үүссэн баталгаажсан карбон кредитийг худалдаж авснаар өөрийн ялгаруулалтыг тэнцвэржүүлдэг.

### Олон улсын зайлшгүй дагаж мөрдөх зах зээл

Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 6.2 дох заалт нь улс орнууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үр дүнгээ харилцан тохиролцсон хэлбэрээр буюу Internationally Transferred Mitigation Outcomes (ITMO) хэлбэрээр солилцох боломжийг олгодог. Тус заалт нь хоёр талын хамтын ажиллагаанд суурилдаг бөгөөд НҮБ-ын Хүрээлэн буй орчныг хамгаалах суурь конвенцын дор тухайн орнуудын Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэдэг. Олон улсын шилжүүлсэн ялгарлын үр дүнг ашиглах үед экспортлогч улс тухайн хэмжээг өөрийн үндэсний зорилтот хувь нэмэртээ тооцохгүй бөгөөд давхар тооцооллоос зайлсхийх үүднээс экспортлогч улс нийт ялгарлын дүнгээс тохируулга хийж хасдаг. Харин импортлогч улс нь шилжүүлэн авч буй ялгарлын үр дүнг өөрийн зорилтод нэмэгдүүлэн тусгадаг.

Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтын зорилго нь олон улсын төвлөрсөн зохицуулалттай нүүрстөрөгчийн зах зээлийг бий болгож, хүлэмжийн хийн ялгарлыг бодитоор бууруулж, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах юм.

Энэхүү зохицуулалтын эхний үе шат нь 2021–2026 оны хооронд хэрэгжиж байгаа бөгөөд энэ хугацаанд улс орнууд сайн дурын үндсэн дээр CORSIA–д оролцож байна. 2024 оны байдлаар дэлхийн 120 гаруй улс CORSIA–д сайн дураар нэгдсэн ба уг зохицуулалт нь 2027 оноос эхлэн зайлшгүй дагаж мөрдөх шатанд шилжиж, оролцогч улс орнууд болон нисэхийн компаниуд тодорхой шалгуур, хуваарийн дагуу ялгарлыг бүртгэх, тайлагнах үүргийг хүлээлгэнэ. Мөн Олон улсын зайлшгүй дагаж мөрдөх зах зээлийн жишээ болгон Европын холбооны нүүрстөрөгчийн зах зээлийг авч үзлээ.

### **Олон улсын сайн дурын зах зээл**

Олон улсын сайн дурын карбон зах зээл нь төрийн зохицуулалтаас гадна аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг санаачилгатайгаар оролцож, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, нөхөн сэргээх төслүүдэд хөрөнгө оруулах, карбон кредит худалдан авах зэргээр хэрэгждэг зах зээл юм.

Уг зах зээлд Gold Standard, Verra зэрэг олон улсын тэргүүлэгч байгууллагууд голлох үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээр байгууллагууд нь төслүүдийг бүртгэх, баталгаажуулах, үнэлэх, хүлэмжийн хийн бууралтын үр дүнг албан ёсоор хүлээн зөвшөөрөх зэрэг чухал үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагын баталгаажуулсан карбон кредит нь олон улсын сайн дурын карбон зах зээлд арилжаалагдах боломжтой болж, зах зээлийн итгэлцэл, ил тод байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулдаг.

Gold standard нь 2003 онд World Wildlife Fund (WWF) болон бусад олон улсын байгаль хамгааллын байгууллагуудын санаачилгаар анх үүсгэн байгуулагдсан. Энэхүү стандарт нь зөвхөн хүлэмжийн хийн бууралтын хэмжээг тооцох бус, уг төсөл тухайн бүс нутаг, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийг давхар үнэлж, баталгаажуулдгаараа онцлог юм. Тус стандарт нь тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаж, уур амьсгалын болон хөгжлийн үр ашгийг нэгэн зэрэг хангасан төслүүдийг дэмжих зорилготой.

## **ДОТООДЫН КАРБОН ЗАХ ЗЭЭЛ**

Дотоодын карбон зах зээл нь тухайн улсын хууль, бодлогын хүрээнд зохицуулагддаг бөгөөд уур амьсгалын зорилт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратеги, эдийн засгийн онцлогт тулгуурладаг. Иймд зах зээл нь зайлшгүй дагаж мөрдөх болон сайн дурын зах зээл гэсэн хэлбэрээр хэрэгжиж болно. Энэ нь тухайн улсын дотоод зохицуулалт, эрх зүйн орчин, зах зээлийн оролцогчдын оролцооноос хамааран уян хатан бүтэцтэй байна.

### **Дотоодын зайлшгүй дагаж мөрдөх зах зээл**

Дотоодын зайлшгүй дагаж мөрдөх нүүрстөрөгчийн зах зээлийн хамгийн том жишээ бол БНХАУ–ын үндэсний нүүрстөрөгчийн зах зээл юм. Тус зах зээл 2021 онд албан ёсоор нээгдсэн бөгөөд эхний шатанд зөвхөн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн салбарыг хамарч, нийт 2,200 орчим цахилгаан станц оролцож байна. Тус зах зээл нь жилд ойролцоогоор 4.5 тэрбум тонн CO<sub>2</sub>–эквивалент ялгаруулалтыг хамардаг ба дэлхийн нийт нүүрстөрөгчийн ялгаруулалтын 30 орчим хувийг төлөөлдөг. Энэ нь БНХАУ –ын хувьд уур амьсгалын бодлогын гол хэрэгсэл болоод байна (ICAP, 2023). 2025 оны байдлаар нэг тонн карбон кредитийн үнэ 60–80 юань буюу ойролцоогоор 8–11 ам.доллар орчим байна (Refinitiv Carbon Market Report, 2025).


### **Дотоодын сайн дурын зах зээл**

Дотоодын сайн дурын зах зээл нь тухайн улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд хүлэмжийн хийг бууруулахын тулд сайн дурын санаачилгаар оролцож, бууралтын үр дүнг баталгаажуулан, зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлдэг зах зээл юм. Дотоодын сайн дурын зах зээлийн гол зорилго нь тухайн орны уур амьсгалын бодлогыг дэмжих, иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоог өргөжүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн дотоод эх үүсвэр бий болгох, орон нутгийн нөхцөлд тохирсон жижиг болон дунд хэмжээний төслүүдийг дэмжихэд оршдог. Мөн олон улсын сайн дурын стандартууд (жишээ нь Gold Standard, VCS) ихэвчлэн өндөр шалгууртай, хэрэгжилтийн өртөг өндөртэй байдаг бол дотоодын системүүд нь илүү хялбаршуулсан, тухайн улс өөрийн нөөц боломжид нийцүүлсэн уян хатан зохицуулалттай байж болдгоороо онцлогтой байдаг.

## КАРБОН КРЕДИТ ҮҮСГЭХ БУЮУ ҮНЭ ТОГТООХ МЕХАНИЗМ

Энэ бүлэгт карбон кредит үүсгэх механизмын талаар танилцуулна. Кредитийг үүсгэх механизмууд нь олон улсын зах зээл болон дотоодын зохицуулалтын онцлогоос хамааран ялгаатай боловч үндсэн агуулгаараа ялгаруулалтыг бууруулах үйл ажиллагааг дэмжих зорилготой байдаг. Энэ нь тоо хэмжээнд суурилсан, үнэд суурилсан, эсхүл эдгээрийг хослуулсан механизмаар хэрэгждэг. Тухайлбал, тоо хэмжээнд суурилсан механизмд cap-and-trade болон baseline-and-crediting механизм багтдаг бол, үнэд суурилсан механизмд нүүрстөрөгчийн татвар хамаарна.

Зураг. Карбон кредит үүсгэх механизм



Эх сурвалж. Asian development bank

### Cap and trade

Cap and trade нь тоо хэмжээнд суурилсан механизм бөгөөд засгийн газрууд хүлэмжийн хийн зохицуулалттай зах зээлийн хүрээнд тодорхой салбаруудад хамаарах аж ахуйн нэгжүүдэд нийт ялгаруулалтын дээд хязгаарыг (cap) тогтоож, тухайн хэмжээнд хүлэмжийн хийн ялгаруулах буюу ялгарлын эрхийн зөвшөөрөл (allowance) олгодог. Энэхүү зохицуулалтын хүрээнд аж ахуйн нэгжүүд жил бүр өөрсдийн бодитоор ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээг зохицуулалтын байгууллагад тайлагнана. Хуваарилагдсан эрхийн хүрээнд компани үйл ажиллагаанаасаа үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг хянаж, хэрэв зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү ялгаруулсан тохиолдолд илүүдэл кредитээ бусад бага ялгаруулалттай оролцогчдоос худалдан авч, нийт ялгарлаа зөвшөөрөгдсөн түвшинд хүргэдэг. Харин эрхийн хэмжээнээс доогуур ялгаруулалттай байсан бол үлдсэн кредитээ бусад оролцогчдод худалдаалах боломжтой бөгөөд энэ нь эдийн засгийн үр ашиг, урамшууллыг бий болгодог.

Зураг. Cap and trade



Source: ICAP 2019c

Эх сурвалж : ICAP


Тус механизмын давуу тал нь нийт ялгаруулалтад дээд хязгаар тавьж, уур амьсгалын зорилттой нийцүүлэхийн зэрэгцээ оролцогчдод зардлын хувьд хамгийн оновчтой хувилбараа сонгох боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл, ялгаруулалтаа бууруулахад өндөр зардалтай компани нь илүү үр ашигтайгаар бууруулж буй байгууллагаас кредит худалдан авах замаар өөрийн үүргийг биелүүлдэг.

### Baseline-and-credit

Baseline and credit механизм нь уур амьсгалын бодлогын чухал хэрэгсэл бөгөөд төслийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон хүлэмжийн хийн ялгаруулалтын бууралтыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой. Хүлэмжийн хий бага ялгаруулдаг төслийн хэрэгжилт эхлэхээс өмнөх ялгаруулалтын хэмжээг суурь түвшин (baseline) гэж тогтоох ба төслийн явцад бодит ялгаруулалт энэ суурь түвшнээс бага байвал ялгаруулалтын зөрүүгээр карбон кредит буюу баталгаажсан ялгаруулалтын бууралтын нэгж үүснэ. Карбон кредит нь зөвхөн тухайн байгууллага хүлэмжийн хийн ялгарлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хэмжээгээр бууруулсан тохиолдолд олгогддог. Ийнхүү үүссэн кредитийг бусад байгууллагууд худалдан авч, өөрийн уур амьсгалын зохицуулалтын үүргээ биелүүлэх, тогтоосон зорилтуудаа хэрэгжүүлэхэд ашигладаг.

Энэхүү механизмын онцлог нь тухайн байгууллага, төсөл хэрэгжүүлэгч өөрөө бодит бууралтыг бий болгосон тохиолдолд л кредит үүсдэг бөгөөд нийт салбар, улс оронд ялгаруулалтын заавал дагаж мөрдөх сар буюу хязгаар тогтоодоггүй.

Зураг. Cap and trade



Эх сурвалж. ICAP

### Carbon tax

Carbon tax буюу нүүрстөрөгчийн татвар нь үнэд суурилсан механизм бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагуудын ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээнд үндэслэн татвар ногдуулдаг. Нүүрстөрөгчийн татвар нь аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны явцад ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээ буюу голчлон нүүрсхүчлийн давхар исэл (CO<sub>2</sub>)–ийн хэмжээнд үндэслэн ногдуулдаг шууд эдийн засгийн зохицуулалтын хэрэгсэл бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаанд эдийн засгийн хөшүүрэг болгон ашигладаг механизм юм. Энэхүү татварын суурь ойлголт нь “ялгаруулалтын өртгийг тусгах” зарчимд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл, хүлэмжийн хий (ялангуяа CO<sub>2</sub>)–ийг ялгаруулж буй аж ахуйн нэгж, байгууллага тухайн ялгаруулалтынхаа хэмжээнд тохирсон хэмжээгээр татвар төлөх үүрэг хүлээдэг.

Уг зохицуулалт нь эдийн засгийн хувьд үр ашигтай бөгөөд уян хатан арга хэрэгсэлд тооцогддог. Учир нь аж ахуйн нэгжүүд өөрсдийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, эсхүл татвар төлөх сонголтын аль нэгийг хийх боломжтой тул хамгийн зардал багатай шийдлийг өөрсдөө сонгон хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Зураг. Карбон кредит үүсгэх цикл



Эх сурвалж: Asian development bank

Эдгээрийг харгалзан үзэхэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор тодорхой төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийдэг. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг бодит хүлэмжийн хийн бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд буурсан хүлэмжийн хийн хэмжээ нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн Gold Standard, Global Carbon Council, Verified Carbon Standard зэрэг байгууллагуудын шалгуур, шаардлагад нийцсэн тохиолдолд баталгаажуулж, нүүрстөрөгчийн кредит хэлбэрээр бүртгэх ба үүний үр дүнд тухайн аж ахуйн нэгж баталгаажсан нүүрстөрөгчийн кредит эзэмших эрхтэй болно. Үүссэн карбон кредитийг зах зээлд арилжаалах, ашиглах эсхүл өөрийн уур амьсгалын зорилтоо биелүүлэхэд тооцох боломжтой болсноор хүлэмжийн хийн бууралтад суурилсан эдийн засгийн урамшууллын цикл бий болж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар карбон зах зээл, түүний үүсэл, хөгжил, бүтэц, карбон кредит үүсэх болон арилжаалагдах процессын талаар судаллаа.

Карбон зах зээл нь газар зүйн байршил болон хамрах хүрээнээс хамааран олон улсын болон дотоодын гэсэн үндсэн хоёр төрөлд ангилагддаг ба зохицуулалтын шинж чанараас хамааран уг зах зээл нь зайлшгүй дагаж мөрдөх (compliance) болон сайн дурын (voluntary) зах зээл гэж хуваагдаж байна.

Олон улсын карбон зах зээл нь улс орнууд хооронд карбон кредит шилжүүлэх, тооцох ажиллагааг хамардаг бөгөөд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл нь энэхүү зах зээлийн эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Тодруулбал, 6.2 болон 6.4 дүгээр заалтуудын хүрээнд улс орнууд өөрийн хэрэгжүүлсэн, эсхүл бусад улсаас худалдан авсан карбон кредитийг Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (NDC)-ийн биелэлтэд тооцох боломжтой.

Дотоодын карбон зах зээл нь тухайн улсын хууль, бодлого, зохицуулалтын хүрээнд хэрэгждэг бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүлэмжийн хий багатай хөгжилд шилжих үндэсний зорилтыг хангахад чиглэдэг. Энэхүү зах зээл нь зайлшгүй дагаж мөрдөх (compliance) болон сайн дурын (voluntary) хэлбэрээр зохион байгуулагдаж, тухайн орны төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн оролцоонд тулгуурладаг.

Карбон кредитийн үнэ тогтоох механизм нь үндсэндээ гурван үндсэн аргачлалд хуваагдана. Үүнд: үнэд суурилсан, тоо хэмжээнд суурилсан, мөн эдгээрийн хосолсон хэлбэр багтдаг. Үнэд суурилсан буюу price-based аргачлалын гол төлөөлөл нь нүүрстөрөгчийн татвар бөгөөд энэ тохиолдолд ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээнд үндэслэн урьдчилан тогтоосон үнийг хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд шууд ногдуулдаг. Харин тоо хэмжээнд суурилсан буюу quantity-based механизм нь cap-and-trade буюу дээд хязгаар тогтоох, зөвшөөрлийн арилжаанд үндэслэдэг. Энэ тохиолдолд нийт ялгарлын хязгаарыг зохицуулагч байгууллагаас тогтоож, зөвшөөрөл олгодог ба эдгээр зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүд хоорондоо зах зээлийн зарчмаар арилжих боломжтой.

Аж ахуйн нэгж, байгууллагууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийж, үр дүнд нь буурсан хүлэмжийн хийн хэмжээг олон улсын байгууллагуудаар баталгаажуулж, нүүрстөрөгчийн кредит үүсгэж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ European Commission. (2023). EU Emissions Trading System (EU ETS). Retrieved from [https://climate.ec.europa.eu/eu-action/eu-emissions-trading-system-eu-ets\\_en](https://climate.ec.europa.eu/eu-action/eu-emissions-trading-system-eu-ets_en)
- ◆ European Commission. (2024). EU Emissions Trading System (EU ETS). Retrieved from [https://climate.ec.europa.eu/eu-action/eu-emissions-trading-system-eu-ets\\_en](https://climate.ec.europa.eu/eu-action/eu-emissions-trading-system-eu-ets_en)
- ◆ European Energy Exchange (EEX). (2024). Market Information. Retrieved from <https://www.eex.com>
- ◆ European Environment Agency. (2023). Trends and projections in the EU ETS in 2023. Retrieved from <https://www.eea.europa.eu>
- ◆ EU ETS Directive 2003/87/EC establishing a scheme for greenhouse gas emission allowance trading within the Community.
- ◆ Guangzhou Futures Exchange. (2025). CCER Market Insights 2025.
- ◆ ICAP. (2023). China National ETS. International Carbon Action Partnership. Retrieved from [https://icapcarbonaction.com/en/?option=com\\_etsmap&task=export&format=pdf&layout=list&systems%5B%5D=55](https://icapcarbonaction.com/en/?option=com_etsmap&task=export&format=pdf&layout=list&systems%5B%5D=55)
- ◆ ICAP. (2024). Emissions Trading Worldwide: Status Report 2024. International Carbon Action Partnership. Retrieved from <https://icapcarbonaction.com>
- ◆ Intergovernmental Panel on Climate Change (IPCC). (2018). Global warming of 1.5°C: An IPCC Special Report on the impacts of global warming of 1.5°C above pre-industrial levels. <https://www.ipcc.ch/sr15/>
- ◆ Refinitiv. (2025). Carbon Market Report Q1 2025. Refinitiv Carbon Research.
- ◆ Refinitiv. (2025). Carbon Market Report: Global Carbon Market Outlook 2025. Refinitiv Carbon Research.
- ◆ United Nations Framework Convention on Climate Change (UNFCCC). (2005). Kyoto Protocol to the United Nations Framework Convention on Climate Change. <https://unfccc.int/resource/docs/convkp/kpeng.pdf>
- ◆ UNFCCC. (2015). Adoption of the Paris Agreement: FCCC/CP/2015/L.9/Rev.1. <https://unfccc.int/resource/docs/2015/cop21/eng/l09r01.pdf>
- ◆ United Nations Framework Convention on Climate Change (UNFCCC). (2015). The Paris Agreement. Retrieved from <https://unfccc.int/process-and-meetings/the-paris-agreement/the-paris-agreement>
- ◆ UNFCCC. (2021). Glasgow Climate Pact: Guidance on cooperative approaches referred to in Article 6.2 of the Paris Agreement. [https://unfccc.int/sites/default/files/resource/cma2021\\_10\\_add1\\_adv.pdf](https://unfccc.int/sites/default/files/resource/cma2021_10_add1_adv.pdf)
- ◆ UNFCCC. (2022). Carbon markets 101: A primer on the Article 6 rulebook. <https://unfccc.int/process-and-meetings/the-paris-agreement/the-paris-agreement/article-6>



## САНХҮҮГЭЭ ХЭРХЭН ТӨЛӨВЛӨХ ВЭ?



Бид “**санхүүгийн төлөвлөлт**”-ийг дараах 6 үе шаттайгаар хийх боломжтой. Ингэснээр орлогоо зохистой хуваарилж, зардлаа хянах замаар **хуримтлал** үүсгэж болно.

1

### Одоогийн нөхцөл байдлаа үнэлэх.

Орлого, зарлагаа тооцож, санхүүгийн бодит байдлаа тодорхойлох.

2

### Зорилгоо тодорхойлох.

Хуримтлал үүсгэх зорилго, хугацаа, хэрэгцээг тодорхойлох.

3

### Санхүүгийн төлөвлөгөө зохиох.

Зорилгодоо хүрэх хугацаа, үе шатыг төлөвлөх.

4

### Төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Санхүүгийн төлөвлөгөөг сахилга баттайгаар хэрэгжүүлж, зардлаа хянах.

5

### Төлөвлөгөөг эргэн харах, залруулах.

Цаг хугацааны явцад гэнэтийн нөхцөл байдал үүсвэл төлөвлөлтөд-залруулга хийх.

Эх сурвалж: "Санхүүгийн хөтөч" ном




## САНХҮҮГЭЭ УДИРДАХ АРГУУД

Бид дараах аргуудаар орлогоо төлөвлөж болох юм...



### 50/20/30 ДҮРЭМ

#### ХАДГАЛАМЖ



#### ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ

- Зээл
- Түрээс
- Хүнс
- Эрүүл мэнд
- Тээвэр гэх мэт



#### ЧӨЛӨӨТ ЗАРЦУУЛАЛТ

- Гадуур гарах
- Ресторан орох
- Худалдан авалт хийх

### 50/15/5 ДҮРЭМ

Хэрэглээний зардал



50%

Урт хугацаат хуримтлал



15%

Гэнэтийн хэрэгцээнд зориулсан хуримтлал



5%



30% Чөлөөт зарцуулалт

## САНХҮҮГЭЭ ТӨЛӨВЛӨХИЙН АЧ ХОЛБОГДОЛ



1

Өрийн дарамтад орохоос сэргийлэх.

2

Орлого, зардлаа удирдаж сурах.

3

Хуримтлалтай болох.

4

Санхүүгийн хувьд бусдаас хараат бус болох.

5

Санхүүгийн сахилга баттай болох.

6

Ирээдүйн зорилгодоо хүрэх боломж нэмэгдэх.


Эх сурвалж: All Your Worth: The Ultimate Lifetime Money Plan (A Guide to Personal Finances)

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### АЛТНЫ ҮНИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДАД ЭДИЙН ЗАСГИЙН НЭМЭЛТ БОЛОМЖ АВЧИРЧ БАЙНА

#### Emerging-Market Countries Are Top Gold Buyers

Biggest changes in gold holdings in 2Q 2025



Source: World Gold Council

Алтны үнийн тасралтгүй өсөлт нь хөгжиж буй орнуудад санхүүгийн гэнэтийн ашиг авчирч, алт олборлодог болон худалдан авдаг орнууд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж байна. Дэлхийн хамгийн гүн алтны уурхай байрладаг Өмнөд Африкт бүртгэлтэй компаниудын хувьцааны ханш сүүлийн 20 жилд байгаагүй хамгийн өсөлттэй санхүүгийн жилээ үдэх төлөвтэй байна. Тухайлбал: Sibanye Stillwater Ltd., AngloGold Ashanti Plc, Gold Fields Ltd зэрэг алт олборлогч томоохон компаниудын зах зээлийн үнэлгээ гурав дахин өссөн байна.

Африкийн алт олборлолтоор тэргүүлэгч Гана Улсын зээлжих зэрэглэлийг олон улсын үнэлгээний “Moody's Ratings” агентлаг сайжруулсан бөгөөд хөгжиж буй орнууд алтны гол худалдан авагчдын тоонд багтаж, улсын сан хөмрөгөө нэмэгдүүлжээ.

АНУ-ын тарифын асуудлаас үүдэлтэйгээр долларын ханш сул, санхүүгийн нөхцөл байдал ерөнхийдөө суларч байгаа энэ үед Төв банкууд алт худалдан авалтаа нэмэгдүүлж алтны ханшийн өсөлтийг эрчимжүүлж байна.

Хөрөнгө оруулагчид ч мөн алтны нөөцөө тогтмол нэмэгдүүлж буй Польш, Турк, Казахстан зэрэг улсуудад анхаарлаа хандуулж байна. Алтны ханшийн өсөлт нь нийтлэгээр эерэг үзэгдэл гэж үзэж болох ч зарим шинжээчид үүнд хэт өөдрөгөөр хандахгүй байхыг зөвлөж байна. Тэдний үзэж буйгаар “алтны нөөц ихтэй улс орнууд

илүү сайн байр суурь эзэлж болох ч үнийн өсөлтийг зээлийн хүчирхэг эх үүсвэр гэж үзэх нь буруу” хэмээн байр сууриа илэрхийлжээ.

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

### ОРОСЫН НЕФТИЙН КОМПАНИУДЫН ЭСРЭГ ШИНЭ



### ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВСНЫ ДАРАА НЕФТИЙН ҮНЭ НЭМЭГДЛЭЭ

АНУ-ын зүгээс ОХУ-ын хамгийн том газрын тос үйлдвэрлэгч Rosneft ба Lukoil компаниудад хориг арга хэмжээ авахаа мэдэгдсэний дараа газрын тосны үнэ өндөр дүнгээр өслөө. Brent төрлийн газрын тосны үнэ 2.9 хүртэлх хувиар өсөж, баррель нь 64 ам.доллар давав. Харин WTI төрлийн газрын тос баррель нь 60 ам.доллароос дээгүүр түвшинд арилжаалагдаж байна.

Ноён Дэвид Окс-ли Capital Economics компанийн уур амьсгал ба түүхий эдийн тэргүүлэх эдийн засагч “АНУ-ын шинэ хоригийн мэдэгдэл нь Оросын эрчим хүчний салбарыг чиглэсэн томоохон алхам бөгөөд энэ нь ирэх жил дэлхийн газрын тосны зах зээлийг алдагдалтай байдалд хүргэж болзошгүй” гэжээ.

Энэ хоригийн үр дүнд Хятад, Энэтхэгийн хэд хэдэн нефтийн компаниуд Оросоос тээвэрлэж буй газрын тосны худалдан авалтаа түр зогсоосон байж болзошгүй гэж арилжааны эх үүсвэрүүд мэдээлжээ. Зах зээлд нийлүүлэлтийн хомсдол үүсэх эрсдэлтэй зэрэгцэн ОПЕК (Газрын тос экспортлох орнуудын байгууллага)

нийлүүлэлтийн дутагдлыг нөхөж, шаардлагатай тохиолдолд гарцаа нэмэгдүүлэх бэлэн гэдгийг Кувейтын Газрын тосны сайд илэрхийлжээ.

Дональд Трампын засаг захиргаа АНУ-ын газрын тосны эрэл хайгуулын бүх эрэг орчмын бүсэд газрын тосны өрөмдлөг хийх зөвшөөрөл олгохоор төлөвлөж байгаа аж. Энэхүү төлөвлөгөөг зарим мужийн захирагч эсэргүүцсэн байр суурьтай байна.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## БНСУ БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 2.5 ХУВЬД ХЭВЭЭР



### ХАДГАЛЛАА

БНСУ-ын Төв банк 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр бодлогын хүүгээ 2.5 хувьд хэвээр хадгалахаар шийдвэрлэсэн зарлалаа. Ингэснээр гурван дахь удаагаа дараалан бодлогын хүүгээ энэ түвшинд барьж байна. Энэхүү мэдээллийн дараа воны ханш ам.долларын эсрэг бага зэрэг чангарсан хөдөлгөөнтэй байна. Тус улсад орон сууцны үнийн өсөлт өндөр түвшинд хэвээр хадгалагдаж, валютын хэлбэлзэл ихтэй байгаа нь Төв банкны шийдвэрт голлон нөлөөлж байна. АНУ-ын Холбооны Нөөцийн банкны шийдвэр гарахаас урьтаж бодлогын хүүгээ хэвээр үлдээсэн нь валютын ханшаа тогтвортой барих оролдлого болж буйг шинжээчид тодотгож байна.

БНСУ-ын барилгын салбар нь ажиллах хүч, тоног төхөөрөмжийн өртөг нэмэгдсэний улмаас уналтад орж, Сөүл хотод шинэ орон сууцны нийлүүлэлт хомсдож байна. Энэ нь орон сууцны үнийг өсгөсөн ч эдийн засгийн

идэвхжилийг удаашруулж байна. Сөүл дэх орон сууцны үнэ, орлогын харьцаа Лондон, Сидней хоёрыг давсан тул БНСУ-ын Засгийн газар үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг гурав дахь удаагаа хязгаарлахаа зарлав.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

## ЕСӨН ДОЛОО ХОНОГИЙН ТУРШ ҮРГЭЛЖИЛСЭН АЛТНЫ ӨСӨЛТ ӨНДӨРЛӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА



Алтны ханш унц нь 4,131 ам.долларт тогтворжиж, алтны үнийн есөн долоо хоног үргэлжилсэн өсөлт зогсох төлөвтэй байна. 10 дугаар сарын сүүлийн хоногийн арилжаагаар 3 орчим хувиар сулрахаар байгааг шинжээчид тооцоолжээ. Цагаан ордноос Пүрэв гаригт мэдээлснээр АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп болон БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпинтэй биечлэн уулзахаар болсон байна. АНУ-аас Хятадын бараанд ногдуулах нэмэлт татварын хэрэгжилт эхлэх 11 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө тус улсын удирдагчид уулзсанаар худалдааны дайн намжиж магадгүй гэсэн хүлээлтийг үүсгээд байна. Энэ нь худалдааны дайн намжиж магадгүй гэсэн хүлээлт үүсгээд байна.


Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

S&P 500 /<sup>^</sup>GSPC/

**6,875.16** +83.47 (+1.23%)




Nikkei 225 /<sup>^</sup>N225/

**50,419.96** -92.36 (-0.18%)




FTSE 100 /<sup>^</sup>FTSE/

**9,653.82** +80.20 (+0.09%)



NASDAQ Composite (<sup>^</sup>IXIC)

**23,637.46** +432.59 (+1.86%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД  
**110**  
ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС  
/үнэ төлбөргүй/  
АВАГЧА  
ХИНА СУУТАН  
АШИГ СОЁРЛАЛЫН ЗОРИУЛ  
АВИАТАЙ ТӨМӨРХ ГАЗАР